


Ховд аймгийн ИТХ-ын 2014 оны 10 дугаар  
сарын 21-ний өдрийн ээлжит бус  
хуралдааны ..... дүгээр  
тогтоолын хавсралт



**ХОВД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ**  
**/2015- 2025 он/**

*Ховд аймаг -Монгол улсын хөгжлийн Баруун Үүд*

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

**Нэгдүгээр бүлэг.** Ховд аймгийн хөгжлийн өнөөгийн түвшин, үнэлгээ

**Хоёрдугаар бүлэг.** Стратеги боловсруулах үндэслэл, үзэл баримтлал, зарчмууд

2. 1. Стратеги боловсруулах үндэслэл
2. 2. Стратегийн үзэл баримтлал
2. 3. Стратегийн үндсэн чиглэл, зарчим

**Гуравдугаар бүлэг.** Ховд аймгийн 2025 он хүртэлх хөгжлийн стратеги

3. 1. Ховд аймгийн хөгжлийн алсын хараа, үнэт зүйлс, эрхэм зорилго
3. 2. Ховд аймгийн 2025 он хүртэлх хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэл
3. 3. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

**Дөрөвдүгээр бүлэг.** Стратегийн хүрэх үр дүнгийншалгуур үзүүлэлт

**Тавдугаар бүлэг.** Стратегийгхэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

- 5.1. Стратегийн удирдлага, зохион байгуулалт
- 5.2. Санхүүгийн эх үүсвэр
- 5.3. Хяналтшинжилгээ, үнэлгээ, олон нийтийн оролцоо

### ХАВСРАЛТ

Хавсралт 1. Ховд аймгийн хөгжлийн стратегийн бүдүүвч

Хавсралт 2. 2015-2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд

## Товчилсон үгийн жагсаалт

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал аж ахуй
МВТ	Мегаватт
ОХУ	Оросын холбооны улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭЗУС	Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан цахилгаан станц
ҮТП	Үйлдвэр, технологийн парк
ХАА	Хөдөө аж ахуй
ШУТ	Шинжлэх ухаан технологи
ШУП	Шинжлэх ухааны парк
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
CAREC	Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа

## УДИРТГАЛ

**“Ховд аймгийн хөгжлийн стратеги, 2015-2025 он” нь мэдлэг, чадвар бүхий иргэд Ховд аймгийн нийгэм эдийн засгийг дунд болон урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх бодлогын цогц баримт бичиг мөн.**

### ЗОРИЛГО

Ховд аймгийн хөгжлийн Стратегийн зорилго нь иргэдийнхээ сайн сайхан амьдралыг цогцлоох, хүний хөгжлийг дэмжих замаар олон тулгуурт, мэдлэгт суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангаж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэн биедаан хөгжих, жишиг аймаг болоход оршино.

### ХАМРАХ ХҮРЭЭ

**Агуулгын хамрах хүрээ:** Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөр, Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги болон Олон Улсын “РИО+20” хурлын “Бидний хүсч буй ирээдүй” тунхаглал, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал хандлага зэрэг баримт бичгүүдийн үзэл санааны хүрээнд энэхүү стратегийг боловсруулсан болно.

**Орон зайн хамрах хүрээ:** Стратегийг Ховд аймгийн нийт нутаг дэвсгэр, аймгийн төв болон бүх сумдыг хамруулан хэрэгжүүлнэ.

**Хугацааны хамрах хүрээ:** Стратегийг дараахь хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

*Нэгдүгээр үе шат.* 2015-2020 онд хот байгуулалтын оновчтой бодлоготой уялдуулан дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх, хүн амын шилжин явах хөдөлгөөнийг сааруулах, хүн амд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээний чанарыг сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийг бий болгоход чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

*Хоёрдугаар үе шат.* 2021-2025 онд дэвшилтэт технологид суурилсан боловсруулах аж үйлдвэрлэл, бүс нутгийн санхүүгийн төв бүхий аймаг болох зорилтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээгээр эрчимжсэн мал ахуй, газар тариаланг хөгжүүлнэ. Түүнчлэн ард иргэдийн амьдрах, бүтээх таатай орчин, нөхцлийг бүрдүүлсэн хөгжлийн загвар нутаг болно.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

### ХОВД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ТҮВШИН, ҮНЭЛГЭЭ

Ховд аймаг нь бэлчээрийн мал аж ахуй болон газар тариалан түлхүү хөгжсөн, олон угсаатны бүлгүүдийн түүх, соёл, уламжлалын өлгийнутаг бөгөөд бүсийн тулгуур төв болох манай аймаг нь газарзүйн байршлын хувьд баруун бүсийн болон бүс нутгийн эдийн засаг, худалдааны зангилаа цэг, аялал жуулчлал, оюуны багтаамжтай үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих таатай боломж нөхцөлтэй, их, дээд сургуулийн томоохон салбаруудтай зэрэг бусад тулгуур төв, орон нутгийн хотуудтай харьцуулахад олон давуу талтай, байгалийн үзэсгэлэнт газар билээ.

Ховд аймгийн 17 сум, 91 багт 2013 оны байдлаар 78.4 мянган хүн ам (20.0 мянган өрх) буюу манай улсын нийт хүн амын 2,67 хувь оршин сууж байна. Хүн амын тоо тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай банийт хүн амын 34,0 хувийг 0-15 насны хүүхэд, 60,8 хувийг 16-59 насныхан буюу хөдөлмөрийн насны хүн ам, 5,2 хувийг 60 ба түүнээс дээш насны өндөр настан эзэлж байна.

Аймгийн хүний хөгжлийн индекс 2013 оны байдлаар 0.756 буюу улсад 21 аймгаас 11-д, хүн амын дундаж наслалт 71.12 буюу улсад 8-д, жендерийн хөгжлийн индекс 0.756 буюу улсад 11-д орж байна.

Ховд аймаг 2013 онд 215,4 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нэг хүнд дунджаар 2,7 сая төгрөг ногдож байгаа бөгөөд баруун бүсийн дундажтай ойролцоо байна. Харин Хангайн, Төвийн бүсийн аймгуудын ДНБ-тэй харьцуулахад хангалтгүй дүр зураг харагдаж байгаа бөгөөд улсын дундажтай харьцуулахад 2,2 дахин бага байна.<sup>1</sup>

Ховд аймгийн эдийн засгийн салбарын бүтэц Монгол Улсын дийлэнх аймгуудтай ижил төстэй буюу олон тулгуурт болоогүй байна. ДНБ-д хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ 58,0 орчим хувь, түүхий эд, импортын худалдаа голлосон үйлчилгээний салбар 37,0 орчим хувийг эзэлж байгаа нь нэмүү өртөг бага шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ голлож байгааг харуулна.

Аж үйлдвэр, уул уурхай, барилгын салбар Ховд аймгийн ДНБ-д 5,2 хувь буюу маш бага хувийг эзлэж байгаа нь эдийн засгийн хөгжлийн нэн тулгамдсан асуудал болж байна. Аж үйлдвэр, барилгын салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бага<sup>2</sup> байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна. Ховд аймаг нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах харьцангуй давуу нөхцөлтэй<sup>3</sup> бөгөөд уул уурхай, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өндөр технологид тулгуурлан мал аж ахуй, газар тариалан, байгалийн түүхий эдийг бүрэн боловсруулж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн бүс нутаг, дэлхийн зах зээлд гаргах боломж байгаа юм.

Аймгийн аж үйлдвэрийн салбарт нэмүү өртөг бага шингэсэн эрчим хүч, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл тэргүүлэх байр суурьтай байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбар нь архи, хүнсний бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, иоджуулсан давс, хувцас үйлдвэрлэлийн чиглэлийн цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж аймгийн дотоод зах зээлийг хангах төдийгөөр хязгаарлагдаж байна.

Ховд аймгийн ДНБ-д үйлчилгээний салбарын эзлэх хувь хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр иржээ. Гэвч тус салбарт бөөний болон жижиглэнгийн худалдаа давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй байгаа буюу нэмүү өртөг шингэсэн санхүүгийн үйлчилгээ, тээвэр ложистик, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, түрээс зэрэг үйлчилгээний бусад хэлбэрүүд төдийлөн хөгжиж чадаагүй байна.

<sup>1</sup>Тухайлбал, Зүүн бүсийн ДНБ-ий хэмжээнээс 1,3 дахин, Төвийн бүсээс 1,6 дахин, Хангайн бүсээс 1,9 дахин бага байна. Эдийн засгийн хөгжлөөр тэргүүлж буй Өмнөговь аймгаас 2,8 дахин, Орхон аймгаас 5,0 дахин, Улаанбаатар хоттой харьцуулахад 3,0 дахин бага байна.

<sup>2</sup> Аймгийн 2010 оны байдлаар аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 26 хувь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 71 хувь эрчим хүч, дулаан, усан хангамжийн салбарт, 3 хувь уул уурхай, олборлох салбарт ногдож байна.

<sup>3</sup>БНХАУ-ын Шинжаань-Уйгарын өөртөө засах орны 20 сая гаруй, ОХУ-ын Алтайн хязгаарын 6 сая гаруй, цаашилбал дундад Азийн 300 сая гаруй хүн амын хэрэгцээг хангах зах зээлд ойр дөт байршилтай.

## **Хөдөө аж ахуйн салбарын хөгжил:**

Аймгийн хөгжилд эдийн засгийн үндсэн салбар болох ХАА онцгой байр суурь эзэлдэг. 2013 оны байдлаар аймгийн хэмжээнд 2.9 сая мал тоологдсон бөгөөд мал аж ахуйн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 60,0 орчим хувийг үйлдвэрлэж байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлд 17 сум, 91 багийн 8.1 мянганмалчин өрхийн хөдөлмөрийн насны 17.0 мянганхүн ажиллаж, жилд дунджаар 11.0-12.0 мянган тн мах, 794.7 тн ноос, 247.2 тн ноолуур, 500-600 мянган ширхэг арьс, шир зах зээлд нийлүүлж байна.

Ховдчууд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох махны хэрэгцээгээ 100 хувь, гурилын 12,6 хувь, сүүний хэрэглээний 64,9 хувь, хүнсний ногооны 95.3 хувийг тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр Ховд аймагт цөөн, дийлэнх нь мах бэлтгэх нядалгааны үйлдвэр байна.

Ихэнх сум (*Цэцэг, Мөст, Мөнххайрхан, Дуут, Зэрэг, Алтай*) Монгол Алтайн нуруунд орших тул үр тариа тариалах газар бага, сэрүүн уур амьсгалтай. Дарви, Манхан, Үенч, Булган сум голын хөндий, эрэг дагуу усалгаатай арвай, Булган, Манхан, Үенч сум бага хэмжээний буудай тариалж байна. Түүнчлэн баруун бүс төдийгүй улсад амтлаг төмс, хүнсний ногоогоор алдартай.

2013 оны байдлаар Ховд аймаг 218,3 тн үр тариа, 11.1 мянган тн төмс, 14.1 мянган тн хүнсний ногоо, 122,4 тн жимс жимсгэнэ хураан авсан.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өссөний зэрэгцээ сүргийн бүтэц алдагдсантай холбоотойгоор нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Ховд аймаг Монгол Улсын цөлжилтөд хамгийн их өртсөн аймгийн нэг болжээ.

## **Аж үйлдвэрийн хөгжил:**

Ховд аймгийн боловсруулах аж үйлдвэрийн салбарт нам болон технологигүй үйлдвэрлэл<sup>4</sup> зонхилж байна. Тиймээс үйлдвэрлэлийн нэр төрөл хэт цөөн, үйлдвэрлэлийн цар хүрээ бага байна. Түүнчлэн ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувь хэмжээ доогуур, бүтээгдэхүүн нь зөвхөн дотоод зах зээлийг хангахад чиглэсэн, өрсөлдөх чадвар багатай байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбар 2013 онд 5,53 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 21.1 хувиар, эрчим хүч, дулаан, усан хангамжийн салбарт 3,91 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар тус тус өссөн байна.

Тус аймагт хүнсний цех, эсгий, төмөр, модон эдлэл хийх зэрэг жижиг дунд үйлдвэр голлон хөгжжээ. Сүүлийн жилүүдэд боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэж байгаа ба томоохон төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ<sup>5</sup> боловсрогдож хэрэгжих шатандаа явж байна.

## **Уул уурхайн салбарын хөгжил:**

Ховд аймаг нь нүүрс, вольфрам, өнгөт металл, нефть, газрын ховор элемент, шохой, барилгын болон гоёлын чулуу зэрэг эрдэс баялагийн арвин нөөцтэй.

2006 оноос эхлэн аймгийн төдийгүй Баруун бүсийн хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх Хөшөөтийн нүүрсний уурхайг ашиглах төслийг хэрэгжүүлж байна. Одоогоор Хөшөөтийн уурхайгаас өөр бүсийн болон аймгийн эдийн засагт дэмжлэг үзүүлэх, ажлын байр шинээр бий болгох томоохон уул уурхай хөгжөөгүй байна.

Халзан Бүргэдтэйн газрын ховор элемент, Бодончийн гялтгануур, Мянгадын Шалын шавар зэрэг ашигт малтмал, эрдэс баялгийн арвин нөөц бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжтой.

<sup>4</sup>Олон улсын жишгээр үйлдвэрлэлийг өндөр, дундаж, нам технологитой ба бусад түүхий эдийн буюу технологигүй гэж 4 ангилдаг.

<sup>5</sup>Ховд аймагт 2013 онд цементийн үйлдвэр байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулж, Засгийн газрын бодлогын зөвлөлөөс Ховд аймагт барих саналыг дэмжүүлсэн байна. Бетон зуурмаг, вакуум цонхны 2, хайрга, талбайн даацын хавтан, хөөсөн блок, хөнгөн бетон, чулууны үйлдвэр зэрэг барилгын материалын үйлдвэр байгуулагдаж, "Алтайн буйлааст" ХХК дүүргэлтийн хөнгөн блок үйлдвэрлэхээр төсөл боловсруулан 2014 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### **Дэд бүтцийн хөгжил:**

Сүүлийн жилүүдэд улсаас баруун бүс тэр дундаа Ховд аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлд ихээхэн анхаарч хөрөнгө оруулалт хийж байна. Тухайлбал, Мянганы хөгжлийн хэвтээ тэнхлэгийн автозам, ОХУ, БНХАУ-ыг холбосон босоо тэнхлэгийн автозамуудтай ойрын 1-2 жилд холбогдох гэж байгаа нь дэд бүтцийн таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Ховд аймаг эрчим хүчний хэрэглээнийхээ 30 орчим хувийг хангаж байгаа бөгөөд эрчим хүчний хангамжийн дийлэнх хувийг хөрш орнуудаас авч байгаа нь анхаарал хандуулах ёстой асуудал болжээ. Тус аймгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн зонхилох хувийг үйлдвэрлэж буй Дөргөний усан цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь чухал юм.

Ховд аймгийн Хөшөөтийн уурхайг түшиглэсэн нүүрс, хийн цахилгаан станц барих нь эрчим хүчний хараат байдлыг бууруулж, байгаль орчны бохирдлыг багасгахад үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Аймгийн төв, 13 сум өндөр хурдны өргөн зурвасын шилэн кабелиар харилцаа холбооны сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд цаашид холбоо, интернет сүлжээний хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### **Үйлчилгээний салбарын хөгжил:**

Ховд аймгийн үйлчилгээний салбар 2013 онд 81,8 тэрбум төгрөгийн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 28,6 тэрбум төгрөгийн ДНБ үйлдвэрлэжээ. Ховд аймгийн үйлчилгээний салбарын ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2008 онд 18,2 тэрбум төгрөг байсан бол 2010 онд эдийн засгийн хямралын нөлөөгөөр 11,8 тэрбум төгрөг болж, 30 гаруй хувиар буурчээ. Үйлчилгээний салбарын ДНБ-ийг ХАА, аж үйлдвэр, барилгын салбартай харьцуулахад сүүлийн жилүүдэд тогтвортой өсч байна<sup>6</sup>.

Хөдөө орон нутгийн хэрэглэгчдийн тоо цөөн, тээврийн зардал өндөр, зах зээлийн багтаамж бага зэргээс хамаарч худалдаа эрхлэгчид тодорхой нэрийн бараагаар төрөлжих, дагнах, томоохон компанийн гэрээт борлуулагчаар ажиллах боломж нөөц хязгаарлагдмал байна. Орон нутгийн бараа түгээлтийн сүлжээнд хамгийн их бэрхшээл үүсгэж буй хүчин зүйл нь тээвэрлэлт, түүний өртөг зардлын асуудал байгаад анхаарал хандуулбал зохистой.

### **Аялал жуулчлалын салбарын хөгжил:**

Ховд аймаг нь байгаль, түүхийн сонин тогтоц, дурсгалт газар олонтой, биологийн өвөрмөц ховор төрөл зүйлээр баян, олон угсаатны бүлгүүдийн өвөрмөц зан заншил, соёл иргэншил зэрэгцэн оршиж хадгалж ирсэн зэрэг нь эко болон этно аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжийг олгож байна.

Бүсийн хэмжээнд жуулчны суурин 9, гэр 110 бааз ажиллаж гадаадын 3477, дотоодын 22711 жуулчин хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн. Гэвч жуулчны баазууд болон зочид буудлын үйлчилгээний чанар тааруу, хүлээн авах хүчин чадал бага байгаа зэрэг сайжруулах ёстой тулгамдсан асуудлууд олон байна.

Ховд аймагт ирэх гадаад, дотоодын жуулчдын тоо ихээхэн өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, гадаадын жуулчдын тоо 2001 онд 180 байсан бол 2010 онд 1352, 2012 онд 1592, дотоодын жуулчдын тоо 2001 онд 180 байсан бол 2010 онд 10476, 2011 онд 14297 болж өсөн нэмэгджээ.

Жуулчдын тоог нэмэгдүүлэхэд агаарын болон зорчигч тээврийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх нь зүйтэй.

### **Хот төлөвлөлт, барилгажилт, газар зохион байгуулалтын байдал:**

---

<sup>6</sup>Ховд аймагт 700 гаруй үйлдвэр, үйлчилгээний цэг салбарууд ажиллаж байгаагаас бөөний болон жижиглэн худалдаа, ахуй үйлчилгээний 577, мах, махан бүтээгдэхүүний 6, эсгийний 3, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн 58, цахилгаан, дулааны үйлдвэрлэл 2, барилгын 15, тээвэр, холбоо 19, санхүү, зээлийн үйлчилгээ 40, эрүүл мэнд, нийгэм хамгааллын 11 цэг салбарууд үйл ажиллагаагаа явуулж ард иргэдийнхээ хэрэгцээг ханган ажиллаж байна.

Ховд хотод 2013 оны байдлаар нийт 26342 хүн ам оршин сууж байгаа бөгөөд үүнээс 4352 иргэн орон сууцанд<sup>7</sup> аж төрж байна. Ховд хотын төлөвлөлт харьцангуй цэгцтэй байгаа бөгөөд цаашид хот төлөвлөлт, хүн амын суурьшил, үйлдвэржүүлэх бодлоготой уялдуулан зөв төлөвлөн өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой. Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах, автозамын сүлжээг өргөтгөх, цэвэр ус, дулаан, цахилгааны хангамжийн найдвартай, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 4296 иргэн, өрх гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хашааны газраа өмчилж, Жаргалант сумын хэмжээнд 2013 онд нийт 612 иргэнд 48.5 га газрыг өмчлүүлээд байна. Цаашид Ховд хотыг иргэддээ ойрхон үйлчилдэг, бүсийн жишиг, ухаалаг хот болгон хөгжүүлэх зүй ёсны шаардлага урган гарч байна.

Ховд аймагт сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажлууд ихээр хийгдэж байгаа нь газар ашиглалтын зориулалт, бүтэц, дүр төрх, газрын төлөв байдалд тоо чанарын асар их өөрчлөлт орж байгааг харуулна. Тэр тусмаа дэлхий дахинаа хурдацтай явагдаж байгаа цаг уурын дулааралтын эрс өөрчлөлтийн улмаас ган зуд болон байгалийн гамшигт үзэгдэл хэсэгчилэн болон нийтийг хамарсан богино хугацааны давтамжтай тохиолдож, байгаль орчин, нийгэм эдийн засгийн хөгжил, иргэдийн амжиргаанд ихээхэн хохирол учруулж байна. Нөгөө талаар хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас байгаль орчин, бэлчээр доройтож, биологийн төрөл зүйл цөөрч, байгалийн гэнэтийн гамшиг, аюул нүүрлэх төлөв ажиглагдаж байна.

### **Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдаж буй асуудлууд**

Тус аймагт нийгэм, эдийн засгийн шийдвэрлэх ёстой дараах тулгамдсан асуудлууд оршин байна. Үүнд:

#### *1. Төрийн болон орон нутгийн бодлогын уялдаа, тогтвортой байдлыг хангах асуудал*

- Манай улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт Ховд аймгийг баруун бүсийн хөгжлийн тулгуур төв болгох, ШУТПарк байгуулах, аж үйлдвэрийг цогцолбороор хөгжүүлэх тухай тодорхой зорилго, зорилтыг дэвшүүлсэн. Нөгөө талаас тус бүс нутгийг хөгжүүлэх асуудлыг бодит ажил болгон хэрэгжүүлэх нь өнөөгийн монголын нийгэм, ялангуяа баруун бүс, Ховд аймгийн иргэд, олон нийтийн захиалга, шаардлага гэж үзэж болно. Ховд аймгийг бүсийн тулгуур төв болгон хөгжүүлсэнээр орон нутгийн тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлж, ажлын байр олноор бий болгож, ард иргэдийн амьжиргааг сайжруулах, улмаар мэдлэг, соёл, аж үйлдвэр, хөгжлийн загвар хот болох боломж бүрдэнэ.
- Түүнчлэн Монгол Улсын Баруун-Үүд буюу Монголыг Европ болон Азийн зах зээлтэй холбох цонх болохын хувьд хөгжлийн бодлого, стратегийг онцгойлон авч үзэх нь чухал.
- Аймаг гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдэд нээлттэй байж бизнесийн таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Ховд аймаг уур амьсгалын өөрчлөлт болон ган зудад эмзэг аймгийн тоонд ордог<sup>8</sup>. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгож, цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах нь томоохон тулгамдсан асуудлын нэг болоод байна.

#### *2. Нийгмийн асуудал*

<sup>7</sup>Орон сууцны шинэ хороолол байгуулахаар 456 айлын орон сууцны барилга барих хэсэгчилсэн төлөвлөгөөг хийлгэж, дэд бүтцийг байгуулах асуудлыг шийдвэрлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих ажлыг эхлүүлээд байна.

<sup>8</sup>Т. Чулуун, М. Алтанбагана. 2010. “Уур амьсгалын өөрчлөлтөд нийгэм-экологийн тогтолцооны эмзэг байдал, дасан зохицох бодлогын сонголтууд”. Баруун бүсийн “Хөгжил, шинжлэх ухаан технологи” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. ЕТГ, УИХ-ын ТГ, ЗГХЭГ, Баруун бүсийн зөвлөл, Шинжлэх ухааны академи, Үндэсний хөгжлийн хүрээлэн. Хуудас 369-384. Улаанбаатар.



- Хүн амын төрөлт, өсөлт тогтвортой байгаа боловч иргэдийн гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөн их байгаатай холбоотойгоор хүн амын тоо дорвитой өсөхгүй байна. Иймд шилжин явах хөдөлгөөнийг сааруулахад чиглэсэн нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Ховд аймаг нь бүсийн мэдлэг оюун соёлын төв болохын тулд боловсрол, соёл, эрүүл мэндийн нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Тус аймаг нь оюунлаг, баялгийг бүтээгч эрүүл саруул иргэдтэй байхын тулд тэдний мэдлэг ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой бодлого хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.
- Олон угсаатны бүлгүүдийн соёлын давтагдашгүй биет болон биет бус өв уламжлалыг хадгалах, хамгаалах, соёл иргэншлийн олон янз байдал бие биесээ хүндэтгэх, эв найртай зэрэгцэн орших нийгмийн ёсзүй, хандлага, төлөвшлийг бий болгох, соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх нь чухал.

### 3. Эдийн засгийн асуудал

- Ховд аймгийн эдийн засаг бэлчээрийн мал аж ахуйд суурилсан өрөөсгөл бүтэцтэй байна. Эдийн засгийн төрөлжилтийг буй болгох зорилгоор Ховд аймаг ХАА-н болон байгалийн нөөц баялгаа ашиглан дунд болон урт хугацаанд өсөн нэмэгдэж буй дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, уул уурхайн болон барилгын материалын үйлдвэрлэл, нэмүү өртөг шингэсэн тээвэр ложистик, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, улмаар экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг бий болгох нь зүйтэй.
- Боловсруулах үйлдвэрийн салбарыг тогтвортой хангах, дэмжих зорилгоор эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг түлхүү хөгжүүлж, жимс, төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна.
- Тус аймагт ХАА-н болон байгалийн түүхий эдээ боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг хөрш улсууд болон бүсийн зах зээлд борлуулж, ДНБ-ээ өсгөх боломж, нөөц бүрэн байна. Тухайлбал, Ховд аймаг жилд 500-600 мянган малын махыг боловсруулж, гадаад зах зээлд эрэлттэй байгаа нөөжилсөн махан бүтээгдэхүүн (*жилд 10-15 мянган тн*), бусад нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой.
- Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор шинжлэх ухаан-технологийн үйлдвэрлэлийн цогцолбор буюу мэдлэгийн кластер, ШУПаркийг хөгжүүлэх зүй ёсны шаардлага гарч байна. Ховд аймагт УТПарк, ШУПарк зэрэг цогцолбор хөгжүүлэх болон хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийн талаар нэлээд олон тооны судалгааны ажил хийгдэж, ТЭЗУС-ны баримт бичиг боловсрогдон гарсан байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар эдгээр төсөл хөтөлбөрийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.
- Ойрын ирээдүйд эрчимтэй хөгжиж байгаа уул уурхайн салбараас олох орлогыг эргэлтэнд оруулах, зүй зохистой ашиглах, үр өгөөжийг нь бүрэн хүртэх, улмаар том үйлдвэрийг дагасан тогтвортой үйл ажиллагаа бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломж байна. Үүний тулд баялгийг ил тод, тогтвортой ашиглах хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь бодлогын цөм байх учиртай.
- Дийлэнх үйлдвэрлэлийн технологийн түвшин нэлээд хоцрогдсон байдалтай байна. Иймд дэвшилтэт болон технологийн багтаамж өндөртэй, байгаль орчинд ээлтэй технологи, үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

- Аймгийн эдийн засгийн хөгжлийг түргэсгэх нэг гол нөхцөл нь зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг хурдацтай хөгжүүлж, найдвартай суурь сүлжээг бий болгох явдал юм.

#### 4. *Санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудал*

- Үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрээ өргөтгөх шинэчлэхэд санхүү, хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн дутмаг байдал нийтлэг байдлаар оршиж байна. Хөгжлийн банкны зээл тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах зэрэг хөрөнгө санхүүгийн олон янз эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байна.
- Үйлдвэрлэл эрхлэгчид төслийн ТЭЗҮ боловсруулах, бүтээгдэхүүний зах зээл, өрсөлдөгчийн судалгаа, эрсдлийн үнэлгээний нарийвчилсан тооцоо хийх чадвар сул байгаа нь хөрөнгө оруулалт олоход голхүндрэл учруулж байна.

#### 5. *Ажиллах хүчний мэдлэг, чадварын асуудал*

- Ховд аймаг нь Ховд их сургууль, Хөгжил политехник коллеж зэрэг оюун, мэдлэг боловсролын төвтэй бөгөөд олон чиглэлээр мэргэжилтнүүд бэлтгэн гаргаж байна. Гэвч төгссөн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар ажлын байрны шаардлага, хэрэгцээг хангахгүй байдал түгээмэл байна.
- Цаашид боловсруулах үйлдвэр, мэдлэгийн кластер, үйлдвэрлэл хөгжихтэй зэрэгцэн мэдлэг, чадвартай нарийн мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ,


## ҮЗЭЛ БАРИМТЛАЛ,ЗАРЧМУУД

### Стратеги боловсруулах үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>9</sup>, Ногоон хөгжлийн бодлого<sup>10</sup>, Баруун бүсийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монголын мянганы хөгжлийн зорилт, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоболон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагуудаас улсын, бүсийн, орон нутгийн хөгжилтэй холбогдон гаргасан тогтоол шийдвэр, төсөл, бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа нь Ховд аймгийн хөгжлийн Стратегид тусгалаа олсон бөгөөд уг стратегийг боловсруулах үндэслэл болно.

Ховд аймгийн хөгжлийн Стратеги нь аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах,хүрээлэн буй байгаль орчны тогтвортой байдлыг хангах ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ хөдөө аж ахуй, газар тариалан, боловсруулах аж үйлдвэрийн салбарт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно.

Орон нутгийн засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчин, хот байгуулалтын асуудлын хүрээнд сумдын хөгжлийн уялдаа, эдийн засгийн шүтэлцээнд авч үзлээ. Төр, хувийн хэвшлийн түншлэл, сайн засаглал, орон нутгийн бие даасан байдал зэргийг хангах нь бүс нутгийн хөгжлийн тулгуур зарчим гэж тодорхойллоо.



<sup>9</sup>УИХ-ын 2010. 7. 15-ны өдрийн 48 дугаар тогтоол

<sup>10</sup>УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол

Ховд аймаг нь Баруун бүсийн хөгжлийн гол тулгуур төв болохын хувьд аймгийн хөгжлийн Стратеги нь бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлоход мөн чухал ач холбогдолтой юм.

Ховд аймгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд бүх төрлийн нөөцийн эх үүсвэрийг хамгийн үр ашигтай, зүй зохистой ашиглах **дотоод орчны хүчин зүйл**, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, даяаршил, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөрөнгө оруулалтын чөлөөтэй урсгал зэрэг **гадаад орчны хүчин зүйлсийг** харгалзан үзэх нь маш чухал юм.

### **Стратегийн үзэл баримтлал**

Уг стратеги нь 2025 он хүртэлх урт, дунд хугацаанд Ховд аймгийн хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, тогтвортой хөгжлийн урьдач нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Стратеги нь Ховд аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, олон тулгуурт эдийн засагт суурилсан тогтвортой хөгжлийг хангах, эрсдлийг бууруулж, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, өндөр технологийн аж үйлдвэрт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжүүлэх үзэл баримтлалд суурилсан. Иймээс орон нутгийн засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчин, хот байгуулалтын хүрээнд асуудлуудыг аймгийн төв, сумдын хөгжлийн уялдаа, эдийн засгийн шүтэлцээг харгалзан авч үзсэн болно.

#### *Хүн ам зүй, нийгмийн салбарын хөгжлийн үзэл баримтлал*

Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, бүтээлч чадавхи, санаачлагыг дэмжих замаар ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх, хүний хөгжил, иргэдийн ажиллаж амьдрах, сурч боловсроход таатай эрүүл орчинг бүрдүүлэхэд чиглүүлнэ.

#### *Эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал*

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн зохистой бүтцийг бүрдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх замаар ДНБ-ийг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.

#### *Экологи, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал*

Байгалийн төрөл бүрийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны хяналт шинжилгээ, мэдээлэл, ил тод байдлын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн баялгийг тогтвортой ашиглах хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогыг баримталж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тогтвортой байдалтай уялдуулах, төр, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, санаачлагыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

#### *Хотын хөгжлийн үзэл баримтлал*

Баруун бүсийн тулгуур төвийн хувьд Ховд хотхүний амьдрах тав тухтай орчныг бүрдүүлсэн, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөг хамгийн бага үзүүлэх, бүсийн нийгэм, соёл, эдийн засаг, санхүүгийн төв байхухаалаг, жишиг хот болгох үзэл баримтлалд тулгуурлана.

### **Стратегийн үндсэн чиглэл, баримтлах зарчмууд**

Стратеги нь үндэсний болон салбарын хөгжлийн баримт бичигт үндэслэсэн, аймгийн чадавхи, нөөц, боломж, дотоод, гадаад орчны нөхцөл, иргэд, бизнес эрхлэгчид, төр, олон нийтийн

байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, санал санаачилгад тулгуурласан дараах үндсэн чиглэлтэй байна. Үүнд:

- Хүний хөгжлийг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх.
- Орон нутгийн нөөц боломж, бүс нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хангах.
- Шинэ техник, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх.
- Авлигагүй, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх.

Стратегийг боловсруулахад дараах зарчмуудыг баримтлав. Үүнд:

- Улс орны болон аймгийн эдийн засаг, нийгмийнхөгжлийн тэргүүлэх чиглэлийг үндэс болгох.
- Эдийн засаг, нийгэм, байгаль орчны бодлогын харилцан уялдааг хангах.
- Эдийн засгийн үр ашиг, үр өгөөжид үндэслэх.
- Үр ашигтай дэд бүтцийг байгуулах.
- Үйлдвэрлэлийн технологийн хөгжил, боловсруулалтын түвшинг харгалзах.
- Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх.
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцан ашигтай түншлэлд тулгуурлах.
- Удирдлагын манлайлал, оролцогч талуудын хяналт оролцоог хангах.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

### ХОВД АЙМГИЙН 2025 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

#### 3.1. ХОВД АЙМГИЙН ХӨГЖЛИЙНАЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС, ЭРХЭМ ЗОРИЛГО

##### *Хөгжлийн алсын хараа нь:*

*Оюун мэдлэгийг дээдэлсэн, амгалан тайван, элбэг хангалуун амьдрал бүхий иргэдтэй, үйлдвэрлэл бизнест ээлтэй, Монгол Улсын болон Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв, ногоон хөгжлийн загвар, цэцэглэн хөгжсөн аймаг болоход чиглэнэ.*

##### *Хөгжлийн үнэт зүйлс нь:*

- Оюуныг дээдэлсэн ард иргэд.
- Амьдралыг тэтгэсэн газар нутаг, баялаг экосистем.
- Хөгжлийн төлөө чин эрмэлзэл, бүтээлчсэтгэлгээ, зүтгэл.

##### *Хөгжлийн эрхэм зорилго нь:*

Нийгэм, эдийн засаг, ногоонхөгжлийн зохистой хүрээнд уламжлал-шинэчлэлийн уялдааг ханган, дэд бүтцээсайжруулан, мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлж, зах зээлд өрсөлдөхчадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий олон тулгуурт эдийн засагтай, бие даасан байдлаа бүрэн хангахуйц чадвар бүхий аймаг болно.

#### 3.2. ХОВД АЙМГИЙН 2025 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

##### **Хөгжлийн зорилт**

- Олон угсаатны бүлгүүдийн оролцоо, эв нэгдлийг хангасан, мэдлэг, ур чадвартай хүнийг бүхталаар хөгжүүлсэн, ажилтай, орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох замаар хүн амаа өсөн нэмэгдүүлж, оюун мэдлэгийг дээдэлсэн, бүтээлч хүнийг хөгжүүлнэ.
- Хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх нээлттэй, хариуцлагатай засаглалыг хөгжүүлж, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ухаалаг, ногоон хот сууринг байгуулж, хөгжүүлэх замаар хүн амынамыдрах аюулгүй, таатай орчныг бүрдүүлнэ.
- Уламжлалт аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах болон мэдлэгт суурилсан аж үйлдвэр, үйлчилгээний зохистой харьцааг хангах замаар өндөр технологи бүхий боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлж олон тулгуурт, ногоон эдийн засгийг бий болгох замаар хөгжил, сайн сайхан амьдралыг цогцлооно.

## Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Хөгжлийн дээрх зорилт бүрийн хүрээнд суурь болох дараах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж байна. Үүнд:

### 1. Оюун мэдлэгийг дээдэлсэн, бүтээлч хүнийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:


- Тэргүүлэх чиглэл 1. Тогтвортой өсөн нэмэгдэх хүн амтай болох.  
Тэргүүлэх чиглэл 2. Оюунлаг, бүтээлч иргэдийг хөгжүүлэх.  
Тэргүүлэх чиглэл 3. Олон угсаатны бүлгүүдийн соёл иргэншлийн уламжлал, шинэчлэл, эв найртай амьдралыг цогцлоох.

### 2. Аюулгүй, таатай амьдрах орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

- Тэргүүлэх чиглэл 4. Хүн байгалийн шүтэлцээг хангах.  
Тэргүүлэх чиглэл 5. Ухаалаг, нээлттэй засаглалтай байх.  
Тэргүүлэх чиглэл 6. Амьдрах таатай орчныг бүрдүүлэх.

### 3. Олон тулгуурт, ногоон эдийн засгийг цогцлоох зорилтын хүрээнд:

- Тэргүүлэх чиглэл 7. Уламжлалт аж ахуй, аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах.  
Тэргүүлэх чиглэл 8. Мэдлэгийн аж үйлдвэр, кластерийг хөгжүүлэх.  
Тэргүүлэх чиглэл 9. Хөгжлийн дэд бүтцийг байгуулах.



Зураг. Хүн төвтэй хөгжлийн загвар

### 3.3 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

#### Тэргүүлэх чиглэл 1. Тогтвортой өсөн нэмэгдэх хүн амтай болох

*Эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, хөдөлмөрлөх, амьдрал ахуйгаа сайжруулах, хөгжих нөхцлийг бүрдүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулан хүн амаа өсгөж хүн төвтэй хөгжлийн үндсийг тавина.*

#### 1.1. Аймгийн хүн амыг өсөн нэмэгдүүлэх стратеги

##### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж бүсийн болон улсын хэмжээнд тэргүүлэх хэмжээнд хүргэнэ.
- Эхийн болон нярайн эндэгдлийг бууруулж, улсын дунджаас доогуур хэмжээнд хүргэнэ.
- Хүн амын өсөлт, тогтвор суурьшилтай амьдрал, гэр бүлийн тогтвортой байдал, амьжиргааг дэмжих зорилготой “Гэр бүл-хөгжил” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Гэр бүлийн гишүүд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх, бага насны хүүхдийн ая тухтай өсөн хүмүүжих орчныг бий болгох зорилгоор 0-2 насны хүүхдийн яслийг аймгийн төв, томоохон суурин газруудад байгуулна.
- Санхүү, зээлийн таатай нөхцлийг бүрдүүлэх замаар гэр бүл, ялангуяа залуу өрхийг орон сууцаар, зорилтот бүлгийг орон байраар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Малчид өвөлжөө, хаваржаандаа хувийн орон сууц барихад нь хөнгөлттэй зээлээр дэмжинэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Гэр бүл, хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх байнгын үйл ажиллагаатай цэцэрлэгт хүрээлэн, төвүүдийг аймаг, сумдын төвүүдэд үе шаттайгаар байгуулна.
- Хувийн хэвшил, ТББ-уудын эх, нялхсын эрүүл мэндийн сувилал, асаргааны төв байгуулах ажлыг хөрөнгө, санхүү, бодлогоор дэмжинэ.
- Түүх соёлоо мэдэх, гэр бүл, ахан дүүсийн эв найртай холбоог бэхжүүлэх зорилгоор удмын ургийн бичиг хөтлөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.
- Иргэд хорших, дундын хуримтлалын сан үүсгэх замаар орон сууц байртай болох санаачлага, үйл ажиллагааг орон нутгийн удирдлагаас санхүү зээл, газар олголтын бодлогоор дэмжинэ.

#### 1.2. Суурьшилт, шилжих хөдөлгөөний талаар баримтлах стратеги

##### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Их, дээд сургууль төгссөн, мэргэшсэн хүний нөөцийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор ажлын байр, орон сууцаархангаж, амьдрал ахуйд нь дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулж ажиллана.
- Шилжин суурьшигчдад үзүүлэх төрийн үйлчилгээг түргэн шуурхай, шат дамжлага багатай үзүүлэхнэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Шилжин суурьшигчдад нийгмийн суурь үйлчилгээг шуурхай үзүүлж, амьдрах таатай орчныг бүрдүүлнэ.



Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Гадаадын өндөр мэргэжилтэн, судлаачид, томоохон хөрөнгө оруулагчдын түр оршин суух, нэвтрэх виз авах асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болно.

### **1.3. Залуучууд, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн стратеги**

***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Залуучуудад нийтийн соёл, ёсзүй, эрүүл амьдрах арга ухааныг төлөвшүүлэх, нийгмийн үйлчилгээг хүргэх зорилготой “Зөв залуу хүн” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Өрхийн хөгжил, өсвөр үе, залуучууд, нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааны төсөв, зардлыг жил бүр дэс дараатай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, өсвөр насныханы хүмүүжил төлөвшлийг бий болгох, амьдрах ухаанд сургах, суралцах зорилготой хөдөлмөр амралтын зусланг сумдад бүсчлэн байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Албан бус хөдөлмөр эрхэлж буй иргэд болон малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- Залуу малчдыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад зориулсан хөгжлийн болон асаргаа сувилгааны төвүүдийг байгуулна.
- Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын үйлдвэрлэсэн гар урлалын бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжинэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Залуу гэр бүлийн хэрэгцээ, бололцоонд нь тохирсон хүүхэд асрах, халамжлах, хөгжүүлэх үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгосон байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг арга зүйн болон санхүүгийн дэмжлэгээр хангана.
- Ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг өргөжүүлэн сум бүрт “АХМАДЫН ӨРГӨӨ” байгуулна.

## **Тэргүүлэх чиглэл 2. Оюунлаг, бүтээлч иргэдийг хөгжүүлэх**

*Мэдлэг, чадвартай, эрүүл хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилтай, орлоготой, бүтээлч иргэдийг төлөвшүүлж хөгжүүлнэ.*

### **2.1. Мэдлэг, ур чадвартай хүнийг хөгжүүлэх боловсролын стратеги**

***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- “Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд “Хүүхэд нас хөгжил” боловсролын дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь боловсролын сургалтын хамрагдалтыг 100.0 хувьд хүргэнэ.
- Ерөнхий боловсролын сургуулиудыг цахим номын сан, мэдээллийн сантай болгож, бүх багш нарыг компьютержүүлж, аймгийн төвд цахим сургалт, үйлчилгээний төвийг байгуулна.

- Олон угсаатны бүлгүүдийн хүүхдүүдэд зориулсан эх хэлний боловсролын чанарыг сайжруулах сургалтын агуулга, арга зүй, технологийг нэвтрүүлэхарга хэмжээг “Хүүхэд нас хөгжил” боловсролын дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
- Олон угсаатны бүлгүүдийн өв соёлыг өвлөн уламжлуулах,бахархах, хөгжүүлэх зорилгоор цоор, тууль, хөөмэй, уран нугаралт, олон ястны бий биелгээний сургалтын агуулга, арга зүй, технологийг боловсруулан, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хөтөлбөрт тусганхэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулна.
- Аймгийн хэмжээнд гүнзгийрүүлсэн, цогцолбор болон төрөлжсөн сургалттай сургууль, байгалийн ухааны лаборатори, зохион бүтээх төвийн тоог нэмэгдүүлнэ.
- Баруун бүсийн “БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН”-г шинээр барьж, ашиглалтанд оруулна.
- Хөдөөгийн багийн бага ангийн сурагчдыг дотуур байранд бүрэн хамруулж, дотуур байрны орчин нөхцөл, үйлчилгээний чанарыг сайжруулна.
- Ерөнхий боловсролын бүх сургууль, цэцэрлэгийн орчинд утасгүй интернэтийн бүсийг бий болгож, камержуулна.
- Хүүхэд, залуучуудын техникийн сэтгэлгээг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж залуу техникчдийн ордон байгуулна.
- Аймгийн төвийн сургуулиуд, хүн ам олон суурьшсан сумдын сургуулийг хүүхдийн автобустай болгоно.
- Хүүхдэд зориулсан “Эрүүл амьдрах, зөв хооллох”“Хөдөлмөрлөхийн ашиг тус” зэрэг хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1 багшид ногдох цэцэрлэгийн хүүхэд болон 1 ангид байх сургуулийн насны хүүхдийн тоог үе шаттай бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- “Үдийн хоол” хөтөлбөрийг аймгийн төвийн сургуулиудад, орон нутгийн онцлогтой уялдуулан хөдөөгийн сургуулиудад хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын бүх сургуулийг стандартын биеийн тамирын заал, талбайтай болгоно.
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн ахлах сургуультай болно.

## 2.2. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах стратеги

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Баруун бүсийнаймгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин үеийн дэвшилтэт технологи бүхий, тандан судалгааны нэгж, зайн оношлогоо бүрэн нэвтэрсэн бүсийн оношлогоо эмчилгээний төв өргөтгөн байгуулна.
- Хүн амын эрүүл мэндийн нэгдсэн цахим мэдээллийн сан, цахим үйлчилгээг нэвтрүүлж “Цаасгүй эмнэлэг” болгон хөгжүүлнэ.
- Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн их эмч, сувилагчдын тоог нэмэгдүүлж, сум, өрхийн эрүүл мэндийн төвийг бохир цэврийн нэгдсэн системд бүрэн холбоно.
- Булган суманд хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн барилгыг шинээр барьж, сум, өрх, сум дундын эрүүл мэндийн төвүүдийг 2020 онд50.0 хувь, 2025 онд 100.0 хувь стандартын байртай болгоно.
- Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн нэгдсэн оношлогооны төвийг байгуулж, үйлчилгээний 30 хүртлэх хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр гүйцэтгэдэг болно.
- Явуулын иж бүрэн тоноглогдсон машин, техник тоног төхөөрөмжтэй нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг сум, багийн иргэдэд 2 жил тутам зохион байгуулна.
- Өндөр настны эмнэлэг байгуулж ажиллуулна.

- Дорно дахины уламжлалт анагаах ухааны төрөлжсөн эмнэлэг байгуулж ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
- Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын амьдарлын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, улс, тив, дэлхийд өрсөлдөх тамирчдыг бэлтгэх дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Хүн амын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээ явуулж байгаа байгууллага, иргэдийг бүх талаар дэмжинэ.
- Олимпийн спортын төрлөөр "Бага олимп"-ийг 4 жил тутам зохион байгуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- БОЭТ-ийг холбоожсон, бүрэн тоноглогдсон машинаар хангаж, яаралтай тусламжийн бүсийн загвар төвийг байгуулан бүсийн аймгуудын болон алслагдсан сумдад нисдэг тэрэг, онгоцоор яаралтай тусламжийг үзүүлэх боломжийг судалж шийдвэрлэнэ.
- Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах Нийгмийн эрүүл мэндийн төв, Нялхсын сувиллыг шинээр барьж тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж бэхжүүлнэ.
- Иж бүрэн оношлогоо, шинжилгээ, тандалт судалгааны лаборатори бүхий Зоонозын өвчин судлалын төвийг байгуулна.
- Сургууль, цэцэрлэгийг 100 хувь эмчээр хангаж, зонхилон тохиолдох шүдний өвчлөлийг бууруулан 2021 он гэхэд “Шүдний өвчлөлгүй хүүхэдтэй аймаг” болгоно.
- Гамшгийн үеийн эм хангамж, хувцас хэрэгсэл аж ахуйн нэн шаардлагатай нөөцийн санг бий болгоно.

### **2.3. Ажилтай, орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ажилгүйдлийн түвшинг 2020 онд 4.0, 2025 онд 3.0 хувьд хүргэж бууруулна.
- Үндсэн хуулиар олгогдсон хүний эрүүл, аюулгүй ажлын байранд ажиллаж хөдөлмөрлөх эрхийг дээдэлсэн жишиг аймаг болгоно.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, журам, дүрэм, стандартын хэрэгжилтийг бүх шатанд сайжруулах гол зорилтыг тавьж, энэ асуудлаар орон нутгийн төсөвт хөрөнгө тусгаж, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөрийн харилцааны үндсэн хэм хэмжээний хэрэгжилтийг ажил олгогчийн нийгмийн хариуцлагын үндсэн шалгуур болгон авч үзэж, орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх ажил үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийдэг журмыг нэвтрүүлнэ.
- Иргэдийн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг орон нутагтаа зохион байгуулах байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг дэмжиж, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болно.
- Компанийн эзэд, ажил олгогчдыг бизнес эрхлэх, компанийн засаглал, хөдөлмөрийн харилцаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр чадавхижуулах сургалт, туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.
- Орон нутгийн уул уурхайн томоохон төслүүдэд ханган нийлүүлэгчээр ажиллах боломжтой аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох, мэдээллээр шуурхай хангах, шаардлагатай мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.
- Жижиг болон өрхийн бичил үйлдвэрлэгч нарт шаардлагатай тоног төхөөрөмж, сав баглаа боодол нийлүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Үйлдвэр аж ахуйн газруудад мастер ажилтаныг бэлтгэн, дадлагажигч, шинэ ажилтнуудыг дагалдуулан сургаж, урамшуулал олгодог болно.
- Ажил мэргэжлийн холбоодыг дэмжих, мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажил явуулахад нь санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аймгийн дэд сангэргэлтийн сантай болгох, шинэ бизнес санаа олсониргэд болон мэргэжлийн боловсролын байгууллагын төгсөгчдөдгарааны зээл олгоно.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг сайжруулах, сургуулийн нийгмийн ажилтнуудыг зөвлөхийн сургалтад хамруулж, ажил мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг сайжруулна.

### **Тэргүүлэх чиглэл 3. Олон үндэстэн, ястны соёл иргэншлийн уламжлал, шинэчлэл, эв найртай амьдралыг цогцлоох**

*Угсаатны бүлгүүдийн түүх, соёлын өвийг хадгалан өвлүүлэн хөгжүүлж, нийтэд сурталчилан үндэстний бахархлыг сэргээх замаар Алтайн бүс нутгийн эдийн засаг, соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.*

#### **3.1. Түүх, соёлын уламжлалыг хамгаалах стратеги**

##### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн хөгжүүлэх бүсийн төвийг Ховд аймагт байгуулна.
- Соёлын биет өвийг сэргээн засварлах, хадгалан хамгаалах, мэргэжлийн боловсон хүчин бий болгож, орон нутгийн хөгжлийн сангийн 0,5-аас доошгүй хувийг биет өвийг хамгаалах, сэргээн засварлахад зарцуулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Баруун монголын угсаатны бүлгүүдийн ахуйн болон язгуур урлагийн наадмыг Ховд аймагт тогтмол зохион байгуулж, “ӨВ СОЁЛЫН ХҮРЭЭЛЭН”-гийн үйл ажиллагааг өргөтгөх, угсаатны соёл судалгааны төв, задгай театр бий болгон, аялал жуулчлалын цогц үйл ажиллагаа явуулна.
- Ховд аймгийн соёлын үнэт зүйлийг бүтээгч, өвлөн уламжлагчийн өвөрмөц дэг жаягийг залуу үед өвлүүлэх, шавь сургалтыг зохион байгуулж, соёлын өвийг өвлөн уламжлагч, билэг авьяастнуудыг дэмжин урамшуулж, сурталчлах, өвийг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Аймгийн угсаатны бүлгүүдийн түүх соёлын өвийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг өргөжүүлнэ.
- Аймгийн номын санг “НОМЫН ӨРГӨӨ” болгон зохион байгуулна.
- Олон угсаатны ардын дуу бүжгийн чуулга байгуулж, язгуур урлагийг өвлүүлэн хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг татах тогтмол үйл ажиллагаа явуулж, язгуур урлагийг сурталчилсан нүүдлийн театр байгуулж, дотоод болон гадаадад тоглолт зохион байгуулна.
- Сумдын Соёлын төвүүдийн үйл ажиллагааг тухайн орон нутгийн соёл уламжлалын онцлогт тулгуурлан хөгжүүлнэ.
- Баруун бүсийн үг, ая, бийрээр урлаачдын урлан бүтээх төв байгуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Ховд аймагт СУИС-ийн харьяа салбар лицей сургууль, Олон угсаатны түүх соёлын судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэнг байгуулна.
- Ховд аймгийн Чандмань суманд "ХӨӨМИЙН ОРДОН", Цэцэг суманд "УРАН НУГАРАЛТЫН ОРДОН", Дуут суманд "ТУУЛЬ, ЦУУРЫН ОРДОН" байгуулна.

### **3.2. Иргэдийн соёл уламжлалыг хөгжлийн хандлагатай нийцүүлэн хөгжүүлэх стратеги**

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх сургалтууд зохион байгуулж, мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох арга хэмжээ зохион байгуулна.
- Номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулж, орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглан үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
- Баруун Монголын соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал, шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан хамгаалах, бататган хөгжүүлэх замаар үндэснийхээ соёлын дэлхийн соёлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, соёл, урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, оюуны өмчийг хамгаалах бодлого баримтална.
- Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдүүлнэ.
- Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийг ардын язгуур болон сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, иргэдийн оюуны хэрэгцээг бүрэн хангана.
- Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн гоо зүйн боловсролыг орон нутаг болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олгоно.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Суманд соёлын төв, зарим суманд соёлын ордон, урлаг-соёл-спортын төв, аймгийн төвд мэргэжлийн урлаг-соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагуудыг ажиллуулж соёлын үйлчилгээг сайжруулна.
- Урлагийн гоц авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулан авьяасыг нь хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ.
- Үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг орон нутгаас дэмжих хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.
- Ховд нутгийн үндэстэн, угсаатны хэл, соёл, зан заншил, язгуур урлагийг сэргээж хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

### **3.3. Олон угсаатны бүлгүүдийн оролцоо, эв нэгдлийг хангасан, оюун санаа, мэдлэг, соёлын төв болох стратеги**

#### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

Нэгдүгээр үе шат (2015-2020 он)

- Баруун Монголын олон угсаатны түүх, урлаг соёлын өвийг хадгалан хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах иж бүрэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Төв Азийн Угсаатны бүлгүүдийн өв соёлын наадмыг өргөжүүлэн Ховд аймагт олон улсын хэмжээнд зохион байгуулна.
- Мэргэжлийн урлагийн байгууллагын ардын язгуур урлагийн тоглолтыг олон улсын хэмжээнд зохион байгуулж, угсаатны бүлгүүдийн соёлыг сурталчилж, аялал жуулчлалын томоохон хөтөлбөр, төсөл боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ардын язгуур урлагийг дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, хөрш зэргэлдээ улс орнуудтай соёлын өдрүүдийг хамтран зохион байгуулах төсөл хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Соёл, аялал, жуулчлалын загвар цогцолбор байгуулна.
- Угсаатны язгуур урлагийн тоглолт, ахуйн соёлыг харуулсан урлагийн тоглолтыг олон улсад аялан тоглох төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Жуулчны баазуудад нүүдлийн театр, язгуур урлагийн хамтлагуудыг бий болгож, үйл ажиллагааг нь дэмжин хамтран ажиллана.
- Ховд нутгаас гаралтай ардын язгуур урлаг болох хөөмий, уран нугаралт, бий биелгээ, тууль цуурыг дэлхий нийтэд сурталчлах, аялал жуулчлалыг татах арга хэмжээг улсын болонхувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлал, соёл амралт, урлаг, шоу-үйлчилгээ, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, музей, бизнесийн шинэ цогцолборуудыг байгуулан соёлын аж үйлдвэрийн дэд бүтцийг Ховд аймгийг үйлдвэржүүлэх хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлнэ.

#### **Тэргүүлэх чиглэл 4. Хүн байгалийн шүтэлцээг хангах**

*Хүрээлэн буй орчны тогтвортой байдал, биологийн олон янз байдлыг хамгаалж, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, бохирдлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлт, байгалийн эрсдэлд дасан зохицох нөхцлийг бүрдүүлнэ.*

#### **4.1. Хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, бохирдлыг бууруулах стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Төв суурин газарт орших голын сав газруудыг түшиглэн цэцэрлэгт хүрээлэн байгуулах үйл ажиллагааг дэмжин, аймгийн төв, сум, суурин газрын гудамж, талбайн зүлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Аймгийн худалдан авалтад байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ бүхий ногоон худалдан авалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг тэргүүн ээлжинд дэмжинэ.
- Аймгийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн талаарбайгаль орчны суурь үнэлгээ, судалгааг хийнэ.
- Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаагүй зуухаар гэр хорооллын айл өрхүүдийг бүрэн хангана.
- Хөшөөтийн уурхайг түшиглэн аймгийн хэрэгцээг хангахуйц коксжуулсан шахмал түлшний үйлдвэр байгуулж хот суурин газрын гэр хорооллыг хямд үнэтэй, утаа бага гаргадаг түлшээр бүрэн хангана.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Цахилгаан халаалтын системийг гэртээ суурилуулсан гэр хорооллын айл өрхийн цахилгааны төлбөрт 30.0 хүртлэх хувиар хөнгөлөлт үзүүлнэ.
- Аймгийн төв, томоохон суурин газруудын автозамын дагуу явган зорчигчийн болон дугуйн замыг байгуулж тохижуулна.
- Хог хаягдлыг боловсруулах, дахин ашиглах үйлдвэрбайгуулахыг бодлогоор дэмжиж, экологийн цэвэр үйлдвэрийн тоог нэмэгдүүлнэ.

## 4.2. Биологийн олон янз байдлыг хамгаалах стратеги

### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Нэн ховор, ховор, гоц ашигт ургамлын тархац нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн орон нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагад хариуцуулан хамгаалах, тарьж ургуулах, зохистой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Нэн ховор, ховор амьтан, ургамал бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ болон орон нутгийн хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Нэн ховор, ховор, аж ахуйн ашигт ургамлыг уугуул нутагт нь сэргээн ургуулах, удмын санг хадгалах баруун бүсийн ургамлын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлнэ.

## 4.3. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох стратеги

### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, эмзэг байдлаа бууруулах зорилгоор аймаг болон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд отор, нөөц бэлчээр, хадлангийн газар болон бэлчээр нутгаа улирлаар сэлгэн хуваарьтай ашиглах зохион байгуулна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхиа бэхжүүлэх, эмзэг байдлын эрсдлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг иргэдийн оролцоотой хэлэлцүүлж шийдвэрлэдэг болно.
- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Цөлжилт, гангийн эрсдлийг бууруулах чиглэлээр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.
- Бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх, бэлчээрийн доройтлыг бууруулах, хамгаалах талаар олон улсын болон мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллана.
- Байгалийн хадлан бэлтгэх бололцоо багатай говь, уулархаг бүс нутгийн сумдад нөөцийн судалгаа хийсний үндсэн дээр орчин үеийн технологи, менежмент, мэдлэг ашиглан зорилтот хадлангийн талбай бий болгох ажлыг зохион байгуулна.
- Хар-Ус нуур дээр нуур судлалын өртөө, Сутай ууланд мөстөл судлалын өртөө байгуулж, судалгаа шинжилгээний ажлыг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын үнэлгээг гаргахад зориулан сумуудад цаг уурын өртөөний сүлжээг өргөтгөн орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- Ган зудад тэсвэртэй, бүтээгдэхүүний гарц сайтай нутгийн шилмэл омгийн малыг өсгөхөд дэмжлэг үзүүлнэ.
- Цаг агаар, бэлчээр ашиглалт, байгалийн аюулт үзэгдлийн урьдчилсан мэдээ, мэдээллийг малчид, иргэдэд шуурхай хүргэх технологийг бүрэн нэвтрүүлнэ.

#### **4.4. Ус, ой зэрэг байгалийн нөөцийг тогтвортой ашиглах стратеги**

##### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Жил бүр сум тус бүр 1-ээс дээш усны эхийг (*гол, булаг, рашаан зэрэг*) хашиж хамгаалах, ундрагыг сайжруулж нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.
- Говь, цөлийн бүсэд байгалийн баянбүрдийг хамгаалах, сэргээх ажлыг төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулна.
- Аймгийн хэмжээнд иргэдийн ундны усыг жил бүр шинжилгээнд хамруулж, шаардлага хангахгүй байгаа худаг, уст цэгийг хаах арга хэмжээ авна.
- Суурьшлын бүс орчмын голуудын усан захыг тэмдэгжүүлэн, голын бүсүүдийн дэглэмийг мөрдүүлж, голыг ахуйн бохирдлоос ангижруулж, нөөцийг хамгаална.
- Ойн сан болон усан сан бүхий газруудыг улсын тусгай хамгаалалтанд авч, байгаль хамгаалах нөхөрлөлдүдтэй гэрээ байгуулан ажиллана.
- Ойн сан бүхий газар болон голын ай сав дагуух модлог ургамлыг хашиж хамгаалах, нөхөн сэргээх, хортон шавьжнаас хамгаалж биологийн ариутгал эмчилгээ хийнэ.
- Малчдын түлшний хэрэгцээг мод орлох бүтээгдэхүүнээр солих, малчин айл өрхүүдийг утаагүй, түлшний хэмнэлттэй, хийн болон хорголон зуух ашиглахыг дэмжиж, голын эргийн харгана, бургас, шаваг зэрэг модлог бутлаг ургамлыг түлшинд хэрэглэх явдлыг зогсооно.
- Ногоон байгууламж, ойн сангийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой, модыг үнэлэн ойн санд худалдан авдаг болно.
- Ганд тэсвэртэй уур амьсгалын хуурайшилттай нөхцөлд дасан зохицон ургах чадвартай, тухайн нутгийн унаган мод, сөөгний тарьц, суулгацаар жил бүр аймгийн хэмжээнд 20 га-аас багагүй талбайд ойжуулалтын ажлыг зохион байгуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Аймгийн хэмжээнд цас борооны усыг тогтоож, хөв цөөрөм, усан сан байгуулах зэргээр ойжуулалт, газар тариалан, уул уурхай, бэлчээрийг усжуулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Усны нөөцийг хамгаалах зорилгоор төвлөрсөн шугамаар ус хэрэглэдэг айл өрх, албан газар, аж ахуйн нэгжийн усны хэрэглээний хяналтын тоолуур тавих ажлыг зохион байгуулж бүрэн нэвтрүүлнэ.
- Ус хамгаалах, арвижуулах, хаягдал бохир усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах санаачилгыг урамшуулж дэмжинэ.
- Алтайн цаадах говийн цөлжилтийг бууруулах зорилгоор заг тариалах үйлдвэрлэлийн чиглэлээр ашиглаж болох мод үржүүлгийн талбайг ойн мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн байгуулна.

#### **Тэргүүлэх чиглэл 5. Ухаалаг, нээлттэй засаглалтай байх**

*Авлигагүй, иргэдэд ойр, нээлттэй төрийн үйлчилгээтэй, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчинг бүрдүүлсэн ухаалаг засаглалтай аймаг болно.*

##### **5.1. Иргэдэд тэгш хүртээмжтэй төрийн үйлчилгээг бий болгох стратеги**

##### *Хэрэгжүүлэх арга хэмжээ:*



Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд аймгийн нутаг дэвсгэрт үйлчилж байгаа нийт хууль эрх зүйн акт, журам, шийдвэрийн нэгдсэн сантай болно.
- Нийтэд ойлгомжтой, заавал мөрдөх, хялбаршуулсан дүрмийг шинэчлэн боловсруулж, нийтээр даган мөрдүүлэх арга хэмжээ авна.
- “Соёлтой иргэн”, “Соёлтой өрх”, “Соёлтой байгууллага”, “Соёлтой хот”, “Соёлтой аймаг” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Багийг иргэдийн байгууллага болгож, хороо, багт эрх мэдэл, чиг үүргийг шилжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Төрийн зарим чиг үүргийг гэрээт үйлчилгээний хэлбэрт шилжүүлж хувийн хэвшлээр гүйцэтгүүлдэг болно.
- Нэг цонхны үйлчилгээг сум, төрийн захиргааны байгууллага бүрт нэвтрүүлж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасган иргэдэд ил тод, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.
- Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх, иргэдийн гаргасан саналыг орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулахад тусгана.
- Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэхийн тулдаймгийн төр, захиргааны байгууллагуудад ил тод байдлын 4 зарчмыг нэвтрүүлж, байгууллагын веб сайтыг тогтмол шинэчилж, иргэдийг үнэн зөв, ил тод мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлнэ.
- Сар бүрийн нэг өдрийг “Иргэдийн өдөр” болгон зохион байгуулж, төрийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгоно.

Хоёрдугаар үе шат (2020-2025):

- “Электрон оффис” технологийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.
- Аймгийн иргэд цахим нэг цонхоор гэрээсээ болон хамгийн ойр цэгээс бүх төрлийн төрийн үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлнэ.
- Байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулж, иргэнээс шаардах баримт бичгийг цөөлж, цаасгүй технологид шилжинэ.
- Судалгаанд суурилсан, үйлчилгээнд тулгуурласан “Иргэн төвтэй”, хууль хэрэгжүүлэхэд чиглэсэн зохистой бүтцийг бий болгоно.
- Оновчтой төлөвлөлттэй хот байгуулалтын загвар боловсруулна.

## **5.2. Ухаалаг, хариуцлагатай засаглал, иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох стратеги**

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- “Ховд хотын зөв удирдлага” системийг бий болгоно.
- “Ховд хотын болон сумдын дүрэм” боловсруулж хэрэгжүүлнэ.
- Төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж авилгагүй төрийн үйлчилгээг бий болгоно.
- Үйлчилгээний хурд, соёлыг сайжруулж, хүнд суртал, авлигын эх үүсвэрүүдийг арилгана.
- Ховд аймгийн харъяа газар, агентлаг, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд “Шилэн данс”-ны тогтолцоог нэвтрүүлэн, иргэдэд тайлагнадаг болно.
- Нээлттэй мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлнэ.
- Иргэдийг төрийн бодлого, шийдвэр гаргахад нөлөөлөх, хэрэгжилтэнд оролцуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Иргэдийн оролцоо”-ны тогтолцоог бий болгоно.
- Худалдан авах ажиллагаанд “Шилэн тендер” системийг нэвтрүүлнэ.

- Иргэдийг орон нутгийг хөгжүүлэх бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд оролцох боломж бүрдүүлнэ.
- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хяналтыг нэмэгдүүлэх замаар төрийн чанартай үйлчилгээг иргэдэд хүргэнэ.
- Төрийн үйл ажиллагаанд хийх хэрэглэгчийн ба хөндлөнгийн үнэлгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хариуцлагын механизмыг бүрдүүлнэ.
- Аймаг, сумын иргэний танхимын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болно.
- Хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулна.

Хоёрдугаар үе шат (2020-2025)

- Төрийн албан хаагчдын ажлыг бүтээмжид чиглэсэн үйл ажиллагааны горимд шилжүүлнэ. Цахим ажлын байрууд бий болно.
- Үр дүнд үндэслэсэн цалин, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлж, албан хаагчдын чадавхийг сайжруулах сургалтыг тогтмолжуулна.
- Төр, нийтийн үйлчилгээний байгууллагууд болон ажиллагсдын өдөр тутмын үйл ажиллагаанд иргэд хяналт тавих тогтолцоог нэвтрүүлнэ.
- Бүх төрлийн тусгай зөвшөөрөл, лиценз олголтын явцыг нийтэд ил тод байлгах “Шилэн лиценз” системийг гашиглана.

### **5.3. Иргэдийн амгалан тайван амьдрах нийгмийн орчныг бүрдүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэхэд иргэд, олон нийтийн хяналт, оролцоог хангах механизм бүрдүүлнэ.
- Ховд хотын болон сумдын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Ховд хот, сумын төвүүдийн агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Малын хулгай, зам тээврийн осол гэх мэт гэмтхэргийн тухай үнэн, зөв мэдээллийг худалдан авах журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хэв журам, онцгой байдлын ажилтнуудынажиллах орчин нөхцлийг сайжруулж, чадавхижуулна.
- Төв суурин газарт нэвтрэх тээврийн хэрэгслийн хяналтын системийг нэвтрүүлнэ.
- “Архигүй, тамхигүй Ховдчууд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны ил тод нээлттэй байх, төрийн албаны ёс зүйг баримтлах, авлигагүй ажиллах орчныг бий болгоно.

Хоёрдугаар үе шат (2020-2025)

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулна.
- Хүн худалдаалах, хар тамхи, мансууралтай тэмцэхэд олон талуудын оролцоогоор хангаж, хяналтыг бий болгоно.
- Алслагдсан гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.

### **5.4. Хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд аймгийн хөрөнгө оруулалтын бодлогыг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлнэ.
- Ховд аймагт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих журам гаргана.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх худалдан авалтанд үндэсний үйлдвэрлэгчдийг болон өмнөх гэрээт ажлаа хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийг давуу эрхтэйгээр оролцуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээнд төсвийн хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлана.
- Оршин суугаа орчиндоо хувийн хөрөнгө оруулалт хийх иргэдийн санаачлагыг дэмжих, урамшуулах журам гаргана.
- Аймагт нэн шаардлагатай төслүүдийг хувийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх замаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татаж, бизнес эрхлэхэд ээлтэй аймаг болно.
- Тусгай зөвшөөрлийг түргэн шуурхай олгох журам боловсруулж мөрдүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Газрын бирж байгуулна.
- Ховд аймгийн брэнд бүтээгдэхүүнтэй болох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## **Тэргүүлэх чиглэл 6. Амьдрах таатай орчныг бүрдүүлэх**

*Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн найдвартай хангасан, аюулгүй амгалан тайван амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн ухаалаг ногоон хот сууринг байгуулж хөгжүүлнэ.*

### **6.1. Эрчим хүч, ус, хүнсний хангамжийн найдвартай байдлыг хангах стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Сумдын усан хангамж, ариутгал татуурга, дулааны нэгдсэн шугам сүлжээний зурагтөсөл, техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Сумдын усан хангамж, ариутгал татуурга, дулааны нэгдсэн шугам сүлжээний зурагтөсөл, техник эдийн засгийн үзүүлэлтийг үе шаттайгаар хийлгэнэ.
- Ховд аймагт 4100 айл өрхийг орон сууцжуулна.
- Сумдыг нэгдсэн дулаан хангамжийн эх үүсвэртэй болгоно.
- Жаргалант сумын 3, 5, 4, 8 халуун ус, 8, 9, 10 дугаар цэцэрлэгүүдийг нарны эрчим хүчээр хангана.
- Аймгийн төвд хог хаягдал дахин боловсруулах, булах төвлөрсөн цэг байгуулж ажиллуулна.
- "Эрүүл хүнс" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Сумдыг усан хангамж, ариутгал татуургын шугам сүлжээнд холбоно.
- Ховд аймагт шинээр 9000 айл өрхийг орон сууцжуулна.

### **6.2. Иргэдийн газрын харилцааны шинэтгэлийн стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд хотын 2030 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг зохион байгуулна.
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- Газар зохион байгуулалтын жил жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, стандартыг хэрэгжүүлнэ.
- Байгууллагуудыг эзэмшлийн газрын доогуур болон ил инженерийн шугам сүлжээний зураглалтай болгож дэд бүтцийн ашиглалтыг сайжруулна.
- Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж онлайн хэлбэрт шилжүүлнэ.
- Ховд, Буянт, Булган голын сав газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах төлөвлөгөө боловсруулж тухайн аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.
- Нийт сумдын нутаг дэвгэрт улс орон нутгийн чанартай замуудын уулзвар, гүүр болон зорчин очих сонирхол бүхий аялал жуулчлал, түүх соёлын дурсгалт газруудын байрлал, суурьшлын бүс, өвөлжөө, хаваржааг тэмдэгжүүлнэ.
- Газар өмчлөлийг 2020 онд нийт хүн амын 50.0 хувьд хүргэнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Газар тариаланг зөв зохистой хөгжүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулж тэргүүний технологи нэвтрүүлэн газрыг шинээр нэмж хагалахгүйгээр талбайн нягтралыг сайжруулах бодлого баримтална.
- Аймгийн төв, улсын чанартай авто замын дагуух иргэнд өмчлүүлэх боломжтой сумдын нутагт газрын төлөв байдал, чанарын баталгаа хийлгэж, газарзүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж ажиллана.
- Сумын Газрын нэгдсэн сангийн тооллого хийж, жил бүр тайлан гаргадаг болно.
- Тариалангийн газрыг давуу эрхээр үнээр нь худалдаж өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.
- Бэлчээр, хадлангийн газрын ашиглалт хамгаалалтын талаар баримтлах чиглэл боловсруулна.
- Сумын төвийн 1:1000-ны масштабтай кадастрын зураглал боловсруулан иргэн аж ахуйн нэгжийн бүртгэлийг хийж тэдгээрт үйлчилгээ үзүүлдэг болно.
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ойрын, дунд, урт хугацааны гэсэн 3 үе шаттай боловсруулж, сумын төвийн тэг гортигийг тодорхой болгоно.
- Сумын төвийн урт, дунд хугацааны төлөвлөлт хийж, үлгэр жишээ тохижилттой суурин газар болгон хөгжүүлнэ.

### **6.3. Ухаалаг, ногоон хот сууринг байгуулж хөгжүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд хотын 2030 он хүртлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу ногоон байгууламжуудыг барьж байгуулна.
- Буянт голын ай сав газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, Бугат үзүүрт усан сан байгуулж Сангийн хэрэм орчмыг ногоон бүс болгоно.
- Ховд аймгийн “Брэнд бүтээгдэхүүний жагсаалт” гаргаж, Ховд хотын болон сумдын төвийгорчин үеийн хот суурингийн загвараар шинэчлэнэ.
- Ногоон орчинг бүрдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг байнгын, өрсөлдөөнт, сайн дурын хэлбэрээр өрнүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Нийгэм, соёл, эдийн засгийн төв болох зорилгоор “Ухаалаг Ховд” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

## **Тэргүүлэх чиглэл 7. Уламжлалт аж ахуй, аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах**

*Эдийн засгийн олон талт бүтцийг бий болгон хөгжүүлэх замаар бүс нутгийн аж үйлдвэрийн төв болно.*

### **7.1. МАА, газар тариаланг хөгжүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

А. МАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ:

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Нийт мал сүргийн 50.0 хувийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, үүний дотроос шилмэл малын мэдээллийн санг 80.0 хувьд хүргэн баяжуулалт хийж, мал ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Бэлчээрийг хуваарьтай ашигладаг уламжлалт аргыг сэргээж сум, багийн түвшинд мөрдөх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон бэлчээрийн даацад тохирсон үүлдэрлэг, таваарлаг чанар өндөртэй мал аж ахуйг хөгжүүлнэ.
- Булган, Жаргалант, Буянт, Ховд, Мянгад, Эрдэнэбүрэн, Манхан, Мөст сумдыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутаг болгож, өндөр ашиг шимт малыг биотехнологийн аргаар үржүүлж малын гаралтай түүхий эдийг боловсруулж экспортлоно.
- Хоршоо, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжиж түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, брокерийн пүүсийн уялдаа холбоог шинэ түвшинд гаргаж ХАА-н бирж, мэргэжлийн холбоодтай хамтран ажиллана.
- Орон нутагт гардаг малын халдварт өвчний голомтыг устгах, халдваргүйжүүлэх, вакцинжуулалтын ажлыг чанартай зохион байгуулж, эрүүл ахуйн шаардлага хангасан экологийн цэвэр мал, махыг экспортлох боломжийг хангаж ажиллана.
- Байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархвар, голомтыг бүртгэн мэдээлэх газарзүйн мэдээллийн системийг нэвтрүүлнэ.
- Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлж, бэлчээрт байгаа худаг уст цэгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, малчдын бүлэг нөхөрлөл, хоршоонд эзэмшүүлж, бэлчээрийн усан хангамжийн түвшинг 40,0 хувьд хүргэнэ.
- Хот суурин газрын ойролцоо гахай, тахиа, зөгийн туслах аж ахуйг байгуулж, хүн амын хүнсний хэрэглээг бүрэн хангана.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Нийт мал сүргийг 100 хувь бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, мал ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Ноосны урамшууллаас олгож байгаа хүн амын орлогын албан татвараас сум бүр өвс тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэн хэвшүүлж, жил бүр нэмэгдүүлэх замаар өвс тэжээлийн фонд байгуулж, бэлчээрийг шинжлэх ухааны үндэслэлтэй хувиартай ашигладаг болгоно.
- Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаанд орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, материаллаг бааз тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлнэ.

Б. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ:

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Буянт, Ховд, Булган, Манхан, Эрдэнэбүрэн сумдын атаршсан талбайд үр тариа, улаан буудай, тэжээлийн ургамал, тосны ургамал тариалах услалтын систем байгуулж усалгаатай талбайн хэмжээг 4000 га-д хүргэнэ
- эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйг хөгжүүлэх үндсэн суурийг бий болгож ажиллана.
- Усалгаатай газар тариалан, хүлэмжийн аж ахуйг бүх талаар дэмжиж, техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй зээл "Лизинг"-д хамруулна.
- Тариалангийн талбайн хэмжээг 4000 га-д хүргэж усалгаатай тариалалтыг жил бүр нэмэгдүүлэх.
- 10.000 метр квадрат хүлэмж шинээр байгуулж, шинэ ургацын ногоогоор иргэдийг тогтмол хангана.
- Нийт дүнгээрээ 3000 тонн мах, 5000 тонн хүнсний ногоо хадгалах зоорь байгуулна.
- Ховд хот, Буянт суманд ногоо боловсруулах, даршлах үйлдвэр байгуулна.
- Жимс жимсгэнэ, чацарганы тариалалтыг 500 га-д хүргэж жимс, жимсгэний боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэх замаар шинэ сортуудыг бий болгох, лабораторийн шинжилгээгээр баталгаажсан үрээр тариалалт хийж чанартай, аюулгүй экологийн цэвэр хүнсийг зах зээлд нийлүүлнэ.
- Орон нутагт үйлдвэрлэж байгаа гуманы бордоог тариалалтанд хэрэглэж хэвших, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж экологийн цэвэр хүнсний ногоогоор иргэдийн хэрэгцээг хангана.
- Тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах, таримлыг сэлгээнд үе шаттайгаар шилжүүлэх, үржил шимийг сайжруулах, ойн зурвас байгуулах ажлыг тогтмол зохион байгуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Төмс хүнсний ногооны тариалалтын хэмжээг 5000 га-д хүргэнэ.
- Үр тариа, чацаргана, жимс жимсгэнэ, тарвас, хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж, хүнсний ногоо, жимс жимсгэнийг нөөшлөх үйлдвэр байгуулан, сайн чанарын дарс, жимсний ундаа үйлдвэрлэн баруун бүсийн хэрэгцээг хангана.
- Мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлж, харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор болгон хөгжүүлнэ.
- Бүх төрлийн хүнсний ногооны стандартын шаардлага хангасан зоорийн аж ахуйг төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулж нарийн ногооны 40.0 хувийг зооринд хадгалах боломж бүрдүүлнэ.

## 7.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Орон нутгийн төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр "ЖДҮ-ИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ДЭД САН"-г байгуулж ЖДҮ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн олон төрлийн хэлбэрээр дэмжинэ.
- Өндөр үнэтэй байнга ашиглагддаггүй тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ашиглах журам баталж ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.
- Жижиг, дунд бизнесийг даатгах даатгалын тогтолцоог бий болгож бизнесийг эрсдлээс хамгаална.
- Эмнэлэг, сургууль, төсөвт байгууллагын цагаан хэрэглэл, зөөлөн эд, "Гэр" төслийн гэрийн хэрэглэл, "Үдийн цай" хөтөлбөр зэргийг орон нутгийн ЖДҮ-үүдэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангах журам гаргаж хэрэгжүүлнэ.

- Боловсруулах болон ЖДҮ-үүдэд шаардлагатай ажилчин, мэргэжилтэй боловсон хүчнийг захиалгаар бэлтгэх, давтан сургах, төгсөгчдийн сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр “Хөгжил” политехникийн коллежтой хамтран зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- “Зээлийн батлан даалтын сан”-гийн хөрөнгийг нэмэгдүүлж 2020 онд 5.0 тэрбум төгрөг, 2025 онд 13.0 тэрбум төгрөгт хүргэнэ.
- Сумдад ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төв байгуулж ЖДҮ шинээр эрхлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх, техник, технологио шинэчилэхэд зөвлөгөө мэдээллээр хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

### 7.3. Боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх стратеги

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх замаар гадаад болон дотоод хөрөнгө оруулагчдыг татаж, үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр технологийн парк байгуулах асуудлыг үйлдвэржүүлэлтийн бодлого, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн хөрөнгө оруулалт хийх замаар байгуулна.
- Бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх сонирхолтой иргэн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан бий болгоно.
- Жилдээ 10-15 мянган тн мах боловсруулах хүчин чадалтай махны үйлдвэр байгуулж, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргана.
- Шохойтын ордыг түшиглэн 100 мянган тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой байгуулж, барилгын материалын үйлдвэрлэлээр Ховд аймгийн хэрэгцээг бүрэн хангадаг болно.
- Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн "цемент, тоосго, дүүргэгч барилгын блок, шохой зэрэг" хөгжүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон нэмүү өртгийн татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг авна.
- Дулааны алдагдал багатай, эдэлгээ удаантай ханын болон дулаалгын материал, хучилтын хөнгөн хавтан, замаска, шилэн хийцийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Барилгын болон бусад зориулалтын чулуун хийц үйлдвэрлэх үйлдвэр хөгжүүлнэ .
- ХАА-н гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж барьж 2016 онд ашиглалтанд оруулна.
- 100 тн тэмээний ноос, 400 тн ноолуурыг үйлдвэрийн аргаар угааж боловсруулан гадаад зах зээлд гаргана.
- Монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал болон гүн боловсруулж, онцлог ширхэгтэй, өрсөлдөх чадвар сайтай шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи нэвтрүүлнэ.
- Арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийж нэмүү өртөг шингээн зах зээлд гаргахын зэрэгцээ ширэн болон савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэглэл, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэр байгуулна.
- Ховд аймгийн нутагт газрын тос, эрдэс баялагийн геологи хайгуулын ажлыг хийж эхэлнэ. Шахмал түлшний үйлдвэр байгуулж Ховд хотын агаарын бохирдлыг бууруулна

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Хөшөөтийн нүүрсний уурхайд кокс, хими, нүүрснээс хий, дулаан, цахилгаан гаргах орчин үеийн технологи бүхий үйлдвэр барина.

- Хөшөөтийн уурхайтай хамтран аймгийн төвийн иргэдийг хямд үнэтэй нүүрсээр хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- Манхан сумын Ганц мод, Дарви сумын Өлзийт, Чандмань сумын Бараан шороот, Дөргөн сумын Мантагийн нүүрсний уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экспортод гаргана.
- Цэцэг сумын вольфрамын ордыг түшиглэн чийдэнгийн үйлдвэр байгуулна.
- Мянгад сумын Халзан Бүргэдтэйн ховор металлын ордыг ашиглалтад оруулж, эрдэс баялагийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулах замаар Хөшөөтийн нүүрсний уурхайд хагас коксын үйлдвэр байгуулна.
- Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэх, угсрах, тэдгээрийн эд анги, сэлбэг хэрэгслийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Ховд аймгийн нутаг дэвсгэрт газрын тосны нөөцийг тогтоох, ашиглах технологийн шийдлийг боловсруулан газрын тосны хэрэгцээг дотооддоо хангах үйлдвэр байгуулна.
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

#### **7.4. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх стратеги**

##### ***Хэрэгжүүлэх арга хэмжээ:***

Нэгдүгээр үе шат (2015-2020 он)

- Байгалийн болон угсаатны аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Угсаатны бүлгүүдийн уламжлал, урлаг, соёлыг хөрш зэргэлдээ орнууд болон дэлхий нийтэд сурталчлан таниулах “Алтайн Алтан үүд” аялал жуулчлалын олон улсын наадмыг ОХУ, Казакстан, БНХАУ-тай хамтарч тогтмол зохион байгуулна.
- Жуулчдын бааз, амралт, сувиллын газар, зочид буудал зэрэг үйлчилгээний газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- Аялал жуулчлалын салбарын мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж ажиллана.
- Байгаль орчинд хоргүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангахад дэмжлэг үзүүлнэ.
- Аялал жуулчлалын эвент бүтээгдэхүүнийг тогтмол зохион байгуулж, гадаадын жуулчдын тоог 50000-д хүргэнэ.
- Буянт голын хөвөөнд аялал жуулчлалын ногоон парк, Ховд хотод баруун бүсийн соёл, урлагийн цогцолбор, 3-5 одтой зочид буудал барьж байгуулна.
- Аялал жуулчлалын бүсүүдийг дотоодын болон олон улсын мэдээллийн сүлжээнд оруулж, зах зээлийн сурталчилгааг оновчтой хийх, аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулна.
- Аялал жуулчлалын бүсүүдэд аяллын төрлүүдээр маршрутуудыг бий болгож, түүх соёлын үнэт зүйлсийг бүртгэн баримтжуулж, маршрутын дагуух замыг засварлаж, түр буудаллах, хоноглох, отоглох цэгүүдийг тэмдэгжүүлж, тохижуулна.
- Байгальд ээлтэй эко аялал жуулчлалын төрлүүдийг дэмжиж, уулын, дугуйн, явган аялал зэрэг аяллын төрлүүдийг хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын үзэсгэлэнд оролцож, аймгийн аялал жуулчлалын салбарын сурталчилгааг хийнэ.
- Аялал жуулчлалын голлох зах зээлийн орнуудад шууд нислэг хийх боломжийг судалж, шинэ чиглэлүүд нээнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):



- Баруун бүсийн соёл урлаг, аялал жуулчлалын цогцолборыг байгуулна.
- Дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, дэн буудлын сүлжээ байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- БНХАУ-тай хиллэдэг сумдад хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлж, хилийн аялал жуулчлалын цогцолбор байгуулна.
- Аялал жуулчлалын анхан шатны менежмент болон хөтөч, гадаад хэлний сургалтууд зохион явуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Олон улсын болон бүсийн аялал жуулчлалын үзэсгэлэн, худалдаа, уулзалтуудыг зохион байгуулна.
- Ховд гол, Хар-Ус нуур, Хар нуур, Дөргөн нуур дээр түшиглэсэн усан аяллын бааз байгуулна.

## **Тэргүүлэх чиглэл 8. Мэдлэгийн аж үйлдвэр, кластерийг хөгжүүлэх**

*Үйлдвэрлэл технологийн болон шинжлэх ухааны парк байгуулж санхүүгийн аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлсэн бүс нутгийн инновацийн төв, оюуны хөгжлийн загвар аймаг болно.*

### **8.1. Үйлдвэрлэл технологийн парк, өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд гол, Буянт гол, Хар ус нуур, Хар нуурын сав газарт Төв азийн орнууд, Арабын орнууд, Африкийн зах зээлийг онилсон мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлнэ.
- Мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерыг архитектурын болон шинжлэх ухаан, технологийн ололтуудыг ашиглан бүтээн байгуулна.
- Технологийн старт-ап компани байгуулах, дэвшилтэт технологи дамжуулах, нутагшуулах ажлыг бүх талаар дэмжин хөгжүүлнэ.
- Мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластеруудын зах зээлийг нислэгийн найман цагийн радиусын бүсэд төлөвлөж хэрэгжүүлнэ.
- Даяарчилсан агаарын зорчигч болон карго тээврийн төвийг мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерыг түшиглэн хөгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэхийн тулд үндэсний, нийтийн өмчит компаниудыг аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдээр үүсгэн байгуулж хөгжүүлнэ.
- Эхний ээлжинд Ховдын ШУП-ийн хүний нөөцийг бүрдүүлэх хүрээнд зочин судлаач илгээх, доктор болон докторын дараах сургалтанд сургах замаар хүнийн нөөцийг бэлтгэж, хамтарсан судалгааны чиглэлүүдийг тодорхойлно.
- Ховд их сургуулийн дэд бүтцийг түшиглэн салбар дундын, ахисан түвшний судалгааны сургууль байгуулна.
- Мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерийг тогтвортой хөгжүүлэхийн тулд дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтарч инновацын их сургуулийг кампус хэлбэрээр байгуулж хөгжүүлнэ.

### **8.2. Бүс нутгийн инновацийн төв, шинжлэх ухааны паркийг бий болгох стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Ховд их сургуулийг судалгаа, инновацид тулгуурласан орчин үеийн энтерпренер их сургууль болгож хөгжүүлнэ.
- "Алтайн уулсын алтан цагираг" хөтөлбөрийн хүрээнд алтайн бүсийн хөрш орнуудын их дээд сургууль, судалгааны байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ҮТП, ШУП байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
- ШУП-д ажиллах хүний нөөцийг бодлоготойгоор эртнээс бэлтгэж, чадавхижуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ШУП-д харьяалагдах байгууллага, хэрэглэгч, оролцогч талуудад зориулж дотоод, гадаадын холбогдох байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Ховд аймаг дахь ШУП-ыг үүсэн байгуулагдсан цагаас нь эхлэн олон улсын ШУП-ын холбооны (IASP) сүлжээнд нэгдэн орох арга хэмжээ авч, гадаадын ижил төстэй ШУП-уудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Оюуны өмчийн үнэлгээний мехнизмийг боловсронгуй болгох, орон нутгийн компаниудын тайлан балансад оюуны өмчийн үнэлгээг оруулдаг болох, оюуны өмчөөрөө барьцаалан зээлэнд хамрагдах боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлнэ.
- “Ховд брэнд”-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг бүх талаар дэмжиж шинэ материал, өндөр үр ашигтай мал, малын тэжээлийн ургамлын шилмэл сорт, ганд тэсвэртэй, арвин ургац өгөх элит үр гаргах, биотехнологи, эм, электроникийн салбарыг түлхүү хөгжүүлнэ.
- Өндөр технологийн салбарыг хөрөнгө оруулалт, санхүүгийн арга хэрэгсэлээр дэмжих зорилгоор Венч хөрөнгө оруулалтын санг орон нутгийн бонд гаргах, тэтгэврийн, даатгалын зэрэг сангуудын чөлөөт үлдэгдлийг төвлөрүүлэх замаар байгуулна.
- Өндөр технологийн компаниудад шаардагдах гадаадын өндөр мэргэжилтэй ажилчдыг ажиллуулах нөхцлийг хангах зорилгоор тэдний ажиллах болон оршин суух визний асуудалд дэмжлэг үзүүлнэ.

### **8.3. Санхүүгийн аж үйлдвэрийн төв болох стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Олон улсын болон дотоодын хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент, эрдсийн болон түүхий эдийн төв, хөрөнгийн бирж зэргийг багтаасан бүс нутгийн санхүүгийн төв байгуулах бизнес төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Шинэ мэдлэг, өндөр технологид тулгуурласан технологийн компаниуд оюуны өмчөө барьцаалан Хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Мэдлэгт тулгуурласан аж үйлдвэрийн кластерыг түшиглэн оффшор олон улсын санхүүгийн төвийг хөгжүүлнэ.
- Санхүүгийн төв болон тансаг зэрэглэлийн орон сууц, худалдааны төв болон амралт зугаалгын газруудыг бий болгоход олон улсын хөрөнгө оруулагчдыг татаж оролцуулна.

### **Тэргүүлэх чиглэл 9. Хөгжлийн дэд бүтцийг байгуулах**

*Орчин үеийн харилцаа холбоо, зам тээвэр, ложистик, эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засагт эрчимтэй нэгдэн орох нөхцлийг бүрдүүлнэ.*

## **9.1. Зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх стратеги**

*Хэрэгжүүлэх арга хэмжээ:*

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Ховд аймагт ногдох хэсэг Ховд-Улаангом, Ховд-Улиастай чиглэлийн хатуу хучилттай замыг барьж ашиглалтанд оруулна.
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 автозамыг барьж ашиглалтанд оруулан уг авто замын дагуух аймгийн төвүүдийг хөрш орнуудын дэд бүтэц, ложистикийн сүлжээ, терминал аж ахуйнуудтай холбоно.
- Ховд-Улаангом-Хандгайт чиглэлийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай автозамыг барьж дуусгана.
- Сумын төвүүдийг аймгийн төв болон ойролцоо байгаа төв замуудтай хатуу хучилттай болон сайжруулсан хайрган замаар холбоно.
- Ховд хотын авто замын сүлжээг оновчтой төлөвлөж, өргөтгөнө.
- Төрөл бүрийн зам тавихад төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар урамшуулан дэмжинэ.
- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр дэмжин сайжруулах, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөлөл багатай зам барилгын техник хэрэгслийн импортыг татварын бодлогоор дэмжин урамшуулна.
- Аймгийн төвд авто тээврийн зорчигч үйлчилгээний цогцолбор байгуулна.
- Ховд хотын дотор нийтийн зорчигч тээврийг иргэдэд хүртээмжтэй, ая тухтай үйлчлэх боломж бүрдүүлнэ.
- Сумдын зорчигч, ачаа, шуудан тээвэрлэлтийн менежментийг сайжруулна.
- Улаанбаатар болон баруун бүсийн аймгуудтай ачаа, зорчигч тээврийн үйлчилгээг өргөтгөнө.
- Ховд хотод том, дунд оврын агаарын хөлөг хүлээн авах чадалтай олон улсын статустай аэродромын өргөтгөлийгхийж, цагт 250-500 хүнд үйлчлэх хүчин чадалтай олон улсын 4С зэрэглэлийн аэровокзал барьж ашиглалтанд оруулна.
- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн, БНХАУ, ОХУ, БНКазахстан улс болон бусад оронд олон улсын нислэг үйлддэг болно.
- Улаанбаатараас Ховдын Булганы чиглэлд онгоц нисэх үйлчилгээг сэргээж, нисэх буух зурвасыг сайжруулна.
- Ховд хотоос ойролцоох аймаг, Булган суманд нислэг үйлддэг болно.
- Агаарын орон зайд нислэг үйлдэх олон улсын агаарын хөлөгт навигацийн үйлчилгээ үзүүлдэг болно.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Зам, тээврийн дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- Олон улсын конвенц, стандарт, шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орно.
- Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн "CAREC" хүрээнд баруун бүсэд босоо тэнхлэгийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.

- Төмөр зам – Хэвтээ тэнхлэгийн шугам Булган боомт хүрснээр Европ-Төв Ази-Хятад-Зүүн Азийг холбосон төмөр замын тээврийн шинэ чиглэлийг эхлүүлнэ.
- Агаарын тээвэр – Баруун бүсийн олон улсын онгоцны буудлыг Ховд хотод байгуулна.
- Ховд Нисэх буудлыг түшиглэн нисгэгч бэлтгэх сургуулилтын бааз байгуулна.
- Алслагдсан сумууд руу тогтмол нислэгийг эхлүүлнэ.

## 9.2. Эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги

### Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Аймгийн төв болон Булган сумын эрчим хүчний найдвартай хангамжийг бий болгохын тулд шинээр дэд станц, трансформаторууд байгуулна.
- Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар сум, суурингуудыг, цахилгаанаар бүрэн хангана.
- Эрдэнэбүрэн суманд 60-100 МВт хүчин чадалтай томоохон УЦС-ыг байгуулах зураг төслийг шинэчлэн боловсруулна.
- Дөргөний УЦС-ын захиргааг аймгийн харьяалалд шилжүүлж хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар хөрөнгө оруулалт хийнэ.
- Хот суурин газруудад агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нар, салхи, газрын гүний дулааныг ашиглах бага, дунд чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолборуудыг барьж байгуулна.
- Хөшөөтийн уурхайд 36 МВ-ын дулааны цахилгаан станц байгуулна.
- Хөшөөтөөс Үенчийн чиглэлд 35 кВ-ын ЦДАШ, дэд станц барина.
- Эрчим хүчний үнийг өдөр шөнийн ялгаатай тарифт шилжүүлнэ.
- Булган гол дээр бага чадлын УЦС байгуулах төслийн судалгааг хийнэ.
- Булган суманд ЦДАШ татах, дэд станц байгуулна.
- Сум, суурин газрын халаалт, дулаан, цэвэр, бохир усны инженерийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэнэ.
- Хүн амын төвлөрөл ихтэй, төв замын ойролцоо үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх боломжтой зарим багуудын төвийг ЦДАШ-д холбох арга хэмжээг ээлж дараатай хэрэгжүүлнэ.
- Ховд хотын шинэ дулааны станцийг хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан албан байгууллага, иргэдийн амины орон сууцтай холбох ажлыг хэрэгжүүлнэ.
- Жаргалант суманд орон сууц, шугам сүлжээний ашиглалт хариуцсан орон нутгийн үйлдвэрийн газар байгуулна.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрснээс хий, дулаан, цахилгаан гаргах орчин үеийн технологи бүхий үйлдвэр барина.
- Эрдэнэбүрэн сумын 60-100 МВт хүчин чадалтай УЦС-ыг барьж эхэлнэ.
- Ховд хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар сум, суурингуудыг, цахилгаанаар бүрэн хангана.
- “100 мянган нарны гэрэл” төслийн хүрээнд малчин өрхийг цахилгааны эх үүсгүүрээр бүрэн хангана.

## 9.3. Орчин үеийн харилцаа холбооны дэд бүтэц, үйлчилгээ хөгжүүлэх стратеги

## **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээ, үйлчилгээг бүрэн шинэчлэх “Цахим Ховд” хөтөлбөрийг боловсруулж хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг аймаг, сумдад бүрэн хэрэгжүүлнэ
- Баруун 3 сумдаас бусад бүх сумдыг 2015 он гэхэд шилэн кабелиар холбож төрийн болон арилжааны цахим үйлчилгээг хүлээн авах бүрэн боломжийг хөдөөгийн хүн амд хүргэнэ.
- Баруун 3 сумын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг сансрын холбоо, радио холбооны технологиор шийдвэрлэнэ.
- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, “Өрх бүрт интернет” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Бүх малчид, сумын төв, суурин газрууд 10-аас доошгүй сувгийн нэвтрүүлэг үзэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.
- Орон нутгийн телестудийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевиз болгон хөгжүүлнэ.
- Бүх сумын төвд утасгүй холбоо, үүрэн телефон, интернетийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.
- Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн электрон үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлж, сум, багийн шуудан хүргэлтийн давтамжийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- Нутгийн төр, захиргааны байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, электрон засаглал, мэдээллийн сан бүрдүүлнэ.
- Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчилж, шилэн кабелийн сүлжээнд холбож аймаг, сумдын хооронд дамжуулах системийн тоон технологит бүрэн шилжүүлж, багийн холбооны ашиглалтыг сайжруулна.
- Аймаг, сумдын төвд мэдээлэл холбооны технологийн шинэ төрлийн үйлчилгээг тухайлбал алсын зайн сургалт, теле эмчилгээний чиглэлийн өндөр хурдны үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Үүрэн телефон хэрэглэгчдийн хүрээг өргөтгөж бүх сум, малчдыг хөдөлгөөнт холбоонд шилжүүлнэ.
- Айл өрх бүрийг компьютержүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Нийт суманд өндөр хурдны шилэн кабель татаж, гар утас, суурин утас, утасгүй холбоо, орчин үеийн интернэттэй болгоно.
- Харилцаа, холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулна.
- Хэвлэлийг электрон хэлбэрээр хүргэж, хэвлэх ажлыг зохион байгуулна.
- Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, энгийн хэрэглээ болгоно.
- Аймгийн төвийн болон сумдын дамжуулах болон холбох байгууламжийг тоон технологид бүрэн шилжүүлнэ.
- Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн санг бүрдүүлнэ.
- Аймгийн төв, сумдын төвийн эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбоно.
- Электрон засаглал, электрон арилжаа, электрон гарын үсэг зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

## **9.4. Транзит тээвэр, ложистикийн төв, хилийн боомтыг хөгжүүлэх стратеги**

## Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Нэгдүгээр үе шат (2015-2020 он):

- ОХУ, БНХАУ, БНКазақстан улстай дамжин өнгөрөх тээвэр худалдаа, "реэкспорт"-ын хэлэлцээр байгуулна.
- Улсын хэмжээнд жишиг болохуйц ачааны төрөлжсөн терминал аж ахуй, ложистик төв, гүний гаалийг Ховд хот орчимд байгуулж, аймгийн болон баруун бүсийн хотын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах сүлжээг бий болгоно.
- Булган сум-Ховд хот-Өлгий хот-Цагааннуурын маршрутаар автотээврийн улс хоорондын транзит ба чингэлгийн тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор гадаад худалдаа-тээврийн цогцолборуудыг байгуулж бүс нутгийн сүлжээнд хамруулна.
- Ховдод хөрөнгө оруулагчдын чуулганыг 2 жил тутамд зохион байгуулж, дамжин өнгөрөх тээвэр худалдаа, ложистикийн төвд хөрөнгө оруулалт татна.
- Булган боомтод өргөтгөл хийж ачаа хүлээж авах, сэлгэн ачих цогцолбор байгуулна.
- Бүс нутаг, тив дамнасан зорчигч, бараа бүтээгдэхүүний дамжин өнгөрөх урсгалыг нэмэгдүүлнэ.
- Булган боомтын дэд бүтцийг сайжруулж, хил дамнасан аялал жуулчлалын сүлжээ бий болгон хөнгөвчилсөн нөхцлөөр хил нэвтрэх асуудлыг шийднэ.
- Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоотой транзит тээвэр, ложистикийн салбарыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн "Транзит Ховд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хилийн боомт орчмын болон Ховд хотын бүс нутагт худалдаа арилжаа, эдийн засгийн чөлөөт бүс нээж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2021-2025 он):

- Бетонон хийц эдлэлийн чанарын баталгаа олгох бүсийн лаборатори, хилийн боомтуудад металл сорьцын баталгаа тогтоох лаборатори болон нефть шингэн түлшний хэмжээг тодорхойлох лаборатори Булган суманд байгуулна.
- Гадаад худалдаа, олон улсын тээвэр, ложистикийн үйлчилгээг дэмжих талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлж, олон улсын тээврийн системтэй холбоно.
- Худалдаа, тээвэр, ложистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаахолбооны технологийн дэвшлийг нэвтрүүлнэ.
- Гаалийн үйлчилгээнд барааг "агуулахаас агуулахад" шилжүүлэх хөдөлгөөний хяналт, зохицуулалтын механизмыг нэвтрүүлнэ.
- Улс хоорондын автотээврийн чиглэлийн дагуу 50-100 км тутамд үйлчилгээний цогц дэд бүтэц "замын буудал, автомашины зогсоол, талбай, автосервис, шатахуун түгээх станц, цайны газар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтын цэг, техникийн түргэн тусламж, нийтийн бие засах газрын үйлчилгээ" бий болгож, олон улсын стандартын түвшинд хүргэнэ.
- Хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, мэдээлэл харилцан солилцох, хамтарч буюу хялбарчилсан хяналт тавих удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авна.
- Хилийн мэргэжлийн хяналтын бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, лаборатори, техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийг олон улсын түвшинд хүргэнэ.
- Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад эрсдлийн удирдлагын тогтолцоог сайжруулан, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- Худалдаа, тээврийн бичиг баримтад агуулагдах мэдээ, мэдээллийг хялбарчлан, нэг стандартад оруулж, цахим хэлбэрт шилжүүлнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

**СТРАТЕГИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (үе шат бүрээр)**

Үзүүлэлт	Суурь он /2013/	2020 он	2025 он
<b>ЗОРИЛТ 1. ОЮУН МЭДЛЭГИЙГ ДЭЭДЭЛСЭН, БҮТЭЭЛЧ ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.</b>			
<i>Ховд аймгийн 2013 онд 0,756 байгаа Хүний хөгжлийн индексийг 2020 онд 0,790; 2025 онд 0,820 хүргэнэ.</i>			
Хүн амын тоо	79000	90000	105000
Дундаж наслалт	71	73	75
Эхийн эндэгдлийн бууралт /10000 промилль/	84,6	65,0	50,0
Нярайн эндэгдэл /1000 промилль/	18,3	15	12
Цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалт /%/	76.5	85.0	100.0
Сургуулийн насны хүүхдийн хамран сургалт /%/	92,6	97,0	100.0
Ерөнхий боловсролын сургуулийн нээлжийн коэффициент	1.37	1.2	1.0
Нэг багшид ногдох сурагчийн тоо	40	30	20
Дотуур байранд хамрагдалтын индекс /%/	85,6	90.0	100.0
Ажилгүйдлийн түвшин /%/	6,3	4,0	3,0
Улсын бүртгэлд орсон Ховд аймгийн билиг авьяастны өвлөн уламжлагчийн тоо	14	20	30
Аймгийн цахим мэдээллийн санд орсон биет өвийн тоо	160	3000	6000
Улсын хамгаалалтанд оруулсан түүх соёлын дурсгалт газрын тоо	9	25	40
<b>ЗОРИЛТ 2. АЮУЛГҮЙ, ТААТАЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.</b>			
<i>Ховд аймаг 2012 онд "Бизнес эрхлэхүй" индексээр улсад 13 дугаар байранд орж байсан бол 2020 онд баруун бүсэд, 2025 онд улсын хэмжээнд тэргүүлнэ.</i>			
Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ /га/	14,5	70	120
Ногоон байгууламжийн талбайн хэмжээ /га/	5	15	30
Ховд хотын агаарын бохирдлын хэмжээ	Азотын давхар исэл /NO2/ 0.047мг/м3, Хүхэрлэг хий /SO2/ 0.082 мг/м3	Азотын давхар исэл /NO2/ 0.037мг/м3, Хүхэрлэг хий /SO2/ 0.050 мг/м3	Азотын давхар исэл /NO2/ 0.020мг/м3, Хүхэрлэг хий /SO2/ 0.30 мг/м3
Тусгай хамгаалалттай газар нутгийн нийт талбайд эзлэх хувь /%/	23.0	35.0	37.0
Инженерийн хангамжтай орон сууцтай айл өрхийн тоо	1500	3000	6000
Газар эзэмшсэн иргэдийн хувь /%/	13,4	50.0	100.0
Авилгын индекс	0,49	0,30	0,20

Ховд аймагт бизнес эрхлэх зардал (төгрөг)	126,000 /2012 онд/	100,000	76,000
Иргэний “Нэг цонх”-оор авах үйлчилгээний тоо	41	150	200-аас дээш
Гэмт хэргийн бууралт (2013 онтой харьцуулбал)	-	2 дахин буурна	4 дахин буурна
Эрчим хүчний хангамжинд аймгийн үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ /%/	30.0	70.0	100.0
Аймгийн үйлдвэрлэдэг стратегийн хүнсний бүтээгдэхүүний хангамж /%/	70.0	85.0	100.0
<b>ЗОРИЛТ 3. ОЛОН ТУЛГУУРТ, НОГООН ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦЛООНО.</b>			
<i>Ховд аймгийн 2013 оны 215,4 тэрбум төгрөгийн ДНБ-ийг 2020 онд 1,0 их наяд, 2025 онд 2,0 их наяд төгрөгт хүргэнэ.</i>			
Малын тоо толгой /сая/ Үүний дотор, эрчимсэн МАА, шилмэл үүлдрийн малын тоо толгой	2,9 0,1	3,0 0,25	3,2 0,4
Усалгаатай газар тариалангийн хэмжээ /га/	2700	4000	10000
ЖДҮ-д олгох зээлийн хэмжээ /тэрбум төгрөг/	3.5	10	30
Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	0,16	5,0	13,0
ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь /%/	5,2	15	25
Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь /%/	20.0	40.0	50.0
Аймагт ирэх гадаадын жуулчдын тоо	2500	5000	8000
Мэдлэгийн эдийн засгийн үзүүлэлт (КЕI), үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засаг, институцийн тогтолцоо</li> <li>• Боловсролтой мэргэшсэн хүн ам</li> <li>• Инновацийн тогтолцоо</li> <li>• Мэдээлэл харилцаа холбооны технологи</li> </ul>	4.50 5.18 2.06 6.31 4.46	5.5 5.20 2.50 6.50 4.70	7.0 6.0 3.5 7.5 5.30
Хатуу хучилттай автозамын хэмжээ /км/	190	780	1200
Агаарын тээврийн зорчигчийн тоо /1 жилд/	28175	60000	120000
Хилийн ачаа тээврийн эргэлт /сая тонн/жил/	2.36	10.0	20.0
Гадаад худалдааны эргэлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	110.0	500.0	1000.0
Төвлөрсөн дулаан хангамжтай сумдын тоо	1	5	17
Усан хангамж, ариутгал татуургын системд холбогдсон сумдын тоо	4	10	17



## **ТАВДУГААР БҮЛЭГ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**

### **5.1. Стратегийн удирдлага, зохион байгуулалт**

А. Ховд аймгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь аймаг, сум, багийн Засаг дарга нарын удирдлагын дор дараах уялдаа холбооны хүрээнд явагдана:

- Энэхүү Стратегийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутаг, засаг захиргааны нэгж, газар хэлтэс, тэдгээрийн удирдлага өөрсдийн чиг үүрэгт хамаарах салбар нэгжийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулж удирдлагаар хангана.
- Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл нь энэхүү Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үндэслэгдэнэ.
- Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд аймаг, сум, багийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, төсөвт тусгана.
- Стратегийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, дараа оны эхний улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.
- Жил бүрийн ажлын тайлан, төсвийн зарцуулалтанд төрийн болон хөндлөнгийн аудитын хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг зохион байгуулна.
- Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргах, цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

Б. Аймаг, сум, багийн хэмжээнд иргэд, олон нийтийн байгууллагын хяналтыг бий болгож, оролцоог ханган ажиллана.

В. Төрийн байгууллагууд Хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхтэй өөрийн чиг үүрэгт хамаарах ажил, арга хэмжээний хүрэн үр дүн, ололт амжилт, гарсан алдаа дутагдал, түүнээс авах сургамж зэрэг цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай гаргах, түгээх, сурталчлах үйл ажиллагааг явуулна.

### **5.2. Санхүүгийн эх үүсвэр**

Ховд аймгийн хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн нөөц, санхүүгийн олон янз эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Монгол Улсын Хөгжлийн банк
- Орон нутгийг хөгжүүлэх сан
- Засгийн Газрын тусгай сангууд
- Гадаадын хөрөнгө оруулалт
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Төр хувийн хэвшлийн түншлэл, концесс
- Орон нутгийн бонд
- Бусад эх үүсвэр

### **5.3. Хяналт, шинжилгээ, үнэлгээ, олон нийтийн оролцоо**

#### ***Хяналт, шинжилгээ үнэлгээ:***

Аймгийн хөгжлийн стратегийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

- ❖ **I үе шат:** Эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2020 оны IY улирал).

❖ **II үе шат:** Эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2025 оны I улирал).

Стратегийн хяналт шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай зардлыг аймгийн төсөвт тусган санхүүжүүлэх бөгөөд холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагууд, орон нутгийн иргэдийн оролцоог зайлшгүй хангана.

Стратегийн хэрэгжилтэнд иргэд, олон нийтийн хяналт оролцоог хангах дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Стратегийн хэрэгжилтийн хүрээнд боловсруулж буй бодлого хөтөлбөр, төсвийн төсөлд иргэд олон нийтийн үзэл бодол байр суурь, тэдний эрх ашгийг хөндсөн асуудалд саналыг тусгадаг механизмыг бий болгоно.
- Стратегийн хэрэгжилтэнд иргэний нийгмийн байгууллага, иргэд, бизнесийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- Төрийн хяналт шинжилгээ, үнэлгээний зарим чиг үүргийг мэргэжлийн чадавхи бүхий ТББ-д шилжүүлэх, тэднээр гүйцэтгүүлэх, хөндлөнгийн дүгнэлт гаргуулдаг болно.
- Стратегийн хэрэгжилтийн үр дүн, үйл ажиллагааны тайланг олон нийт, иргэдэд нээлттэй таниулж сурталчилна.

## **XABCPAJT**

### Хавсралт 1. Ховд аймгийн хөгжлийн стратегийн бүдүүвч

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ	ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	СТРАТЕГИ
<b>1. ОЮУН МЭДЛЭГИЙГ ДЭЭДЭЛСЭН, БҮТЭЭЛЧ ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.</b>	<b>Тэргүүлэх чиглэл 1.</b> Тогтвортой өсөн нэмэгдэх хүн амтай болох	1.1. Аймгийн хүн амыг өсгөн нэмэгдүүлэх стратеги 1.2. Суурьшилт, шилжих хөдөлгөөний талаар баримтлах стратеги 1.3. Залуучууд, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 2.</b> Оюунлаг, бүтээлч иргэдийг хөгжүүлэх	2.1. Мэдлэг, ур чадвартай хүнийг хөгжүүлэх боловсролын стратеги 2.2. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах стратеги 2.3. Ажилтай, орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 3.</b> Олон үндэстэн, ястны соёл иргэншлийн уламжлал, шинэчлэл, эв найртай амьдралыг цогцлоох	3.1. Түүх, соёлын уламжлалыг хамгаалах стратеги 3.2. Иргэдийн соёл уламжлалыг хөгжлийн хандлагатай нийцүүлэн хөгжүүлэх стратеги 3.3. Олон угсаатны бүлгүүдийн оролцоо, эв нэгдлийг хангасан, оюун санаа, мэдлэг, соёлын төв болох стратеги
<b>2. АЮУЛГҮЙ, ТААТАЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.</b>	<b>Тэргүүлэх чиглэл 4.</b> Хүн байгалийн шүтэлцээг хангах	4.1. Хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, бохирдлыг бууруулах стратеги 4.2. Биологийн олон янз байдлыг хамгаалах стратеги 4.3. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, эрсдлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох стратеги 4.4. Ус, ой зэрэг байгалийн нөөцийг тогтвортой ашиглах стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 5.</b> Ухаалаг, нээлттэй засаглалтай байх	5.1. Иргэдэд тэгш хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэх стратеги 5.2. Ухаалаг, хариуцлагатай засаглал, иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох стратеги 5.3. Иргэдийн амгалан тайван амьдрах нийгмийн орчныг бүрдүүлэх стратеги 5.4. Хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 6.</b> Амьдрах таатай орчныг бүрдүүлэх	6.1. Эрчим хүч, ус, хүнсний хангамжийн найдвартай байдлыг хангах стратеги 6.2. Иргэдийн газрын харилцааны шинэтгэлийн стратеги 6.3. Ухаалаг, ногоон хот сууринг байгуулж хөгжүүлэх стратеги
<b>3. ОЛОН ТУЛГУУРТ, НОГООН ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦЛООНО.</b>	<b>Тэргүүлэх чиглэл 7.</b> Уламжлалт аж ахуй, аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах	7.1. МАА, газар тариаланг хөгжүүлэх стратеги 7.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги 7.3. Боловруулах үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх стратеги 7.4. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 8.</b> Мэдлэгийн аж үйлдвэр, кластерийг хөгжүүлэх	8.1. Үйлдвэрлэл технологийн парк, өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги 8.2. Бүс нутгийн инновацийн төв, шинжлэх ухааны паркийг бий болгох стратеги 8.3. Санхүүгийн аж үйлдвэрийн төв болох стратеги
	<b>Тэргүүлэх чиглэл 9.</b> Хөгжлийн дэд бүтцийг байгуулах	9.1. Зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх стратеги 9.2. Эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги 9.3. Орчин үеийн харилцаа холбооны дэд бүтэц, үйлчилгээ хөгжүүлэх стратеги 9.4. Транзит тээвэр, ложистикийн төв, хилийн боомтыг хөгжүүлэх стратеги

**Хавсралт 2. Ховд аймгийн хөгжлийн стратегийн I үе шат /2015-2020 он/-нд  
хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд**

№	Хөрөнгө оруулалтын төслийн нэр	Байршил	Хүчин чадал	Хөрөнгө оруулалтын төрөл
<b>Нэг. Дэд бүтцийн төслүүд</b>				
1	Сумдын төвлөрсөн дулаан хангамж	Булган, Мөнххайрхан, Дуут, Дөргөн, Чандмань, Цэцэг, Мөст, Ховд, Мөнххайрхан, Буянт, Манхан, Үенч		Төр, хувийн хэвшил, концесс
2	Ховд голын Шижигтэйн хавцлын усан цахилгаан станц	Эрдэнэбүрэн	64МВт, жилд 230 саякВтцаг ЦЭХ үйлдвэрлэнэ	Төр, хувийн хэвшил концесс
3	Нар, салхины цахилгаан станц	Дөргөн сум	Тус бүр 10 МВт	Хувийн хэвшил
4	Чоно харайхын голын төмөр бетон гүүр	Дөргөн сум	37 мурттай	Төр, концесс
5	Зорчигч тээврийн авто вокзал	Жаргалант сум	3 дугаар зэрэглэл Авто үйлчилгээ 50-75 метр квадрат Автобус зогсох зогсоол 240 метр квадрат	Улсын төсөв, хувийн хэвшил
6	1000 айлын орон сууцны хороолол	Жаргалант сум	1000 айл	Төр, хувийн хэвшил
7	500 айлын хаус орон сууцны хороолол		500 айл	Төр, хувийн хэвшил
8	Жаргалант сумын Бугат багт баригдах 480 айлын орон сууцны хороолол		480 айл	Төр, хувийн хэвшил
9	600 айлын орон сууцны хороолол		600 айл	Төр, хувийн хэвшил
10	700 айлын орон сууцны хороолол		700 айл	Төр, хувийн хэвшил
11	Дулаан, цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл	Жаргалант сум	15 км	Төр, концесс
12	Мөнххайрхан- Хуурай Сэнхэр чиглэлийн хайрган хучилттай автозам	Мөнххайрхан сум	50 км	Төр, концесс
15	Хөшөөтөөс Үенчийн чиглэлд 35 кВ-ын ЦДАШ, дэд станц барих	Цэцэг сум	35кВ	Төр, концесс
13	Булган голын УЦС	Булган сум	Булган сумыг хангах	Төр, хувийн хэвшил концесс
14	Дулааны цахилгаан станц	Манхан сум, Зэрэг сум	12-36МВт	Төр, хувийн хэвшил концесс
20	Ачаа тээврийн ложистик төв	Жаргалант сум	Жилдээ 100,0-300,0 мянган тонн ачаа боловсруулах “С” зэрэглэлийн	Төр, хувийн хэвшил
21	Дарви суманд автовокзал, техникийн үйлчилгээний	Дарви сум	4 дугаар зэрэглэл Авто үйлчилгээ	Төр, хувийн хэвшил

	төв		50-75 метр квадрат Автобус зогсох зогсоол 120 метр квадрат	
22	Төрөлжсөн авто засварын газар	Жаргалант сум	Тоёота, ниссан, хьюндай, нордбенз	Хувийн хэвшил
32	Услалтын систем	Эрдэнэбүрэн, Ховд, Буянт сум	1000 га-гийн услалтын систем	Төр, хувийн хэвшил
23	ХАА-н гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж	Жаргалант сум	1500 м.куб химийн болон механик бохирдолтой усыг цэвэрлэх хүчин чадалтай	Төр, хувийн хэвшил
<b>Хоёр. Үйлдвэрлэл, бизнесийн төслүүд</b>				
16	Бетон зуурмагийн үйлдвэр	Жаргалант сум	Өдөрт 600.0м <sup>3</sup> бетон зуурмаг үйлдвэрлэх	Хувийн хэвшил
17	Эрдэс шилэн хөвөнгийн үйлдвэр	Жаргалант сум	МодельHZS90 Хүчинчадал(м <sup>3</sup> /h) 90	Хувийн хэвшил
18	Шилний үйлдвэр	Жаргалант сум		Хувийн хэвшил
19	Ханын материалын үйлдвэр	Жаргалант сум	Хоногт 300ш	Хувийн хэвшил
24	Ноос ноолуурын анхан шатны боловсруулалтхийх үйлдвэр	Жаргалант сум	1000 тн ноолуур, 2000 тн ноосонд анхан шатны боловсруулалт хийх хүчин чадалтай	Хувийн хэвшил
25	Арьс, шир боловсруулах үйлдвэр	Жаргалант сум	800000 ш арьс шир, боловсруулах хүчин чадалтай	Хувийн хэмшил
26	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	Жаргалант сум, Булган сум	Жилд 3 сая литр сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр	Хувийн хэвшил
27	Олон улсын стандартад нийцсэн махны үйлдвэр	Жаргалант сум	3000 тн мах боловсруулах хүчин чадалтай	Хувийн хэвшил
28	10000 метр квадрат өвөл, зуны хүлэмж шинээр байгуулах	Жаргалант сум, Буянт сум	10000 метр квадрат талбайтай	Хувийн хэвшил
29	1000 тонны багтаамж бүхий механикжсан ногоо хадгалах зорь	Жаргалант сум	1000тн	Төр хувийнхэвшил
30	Сүүний үхрийн ферм	Эрдэнэбүрэн, Жаргалант, Буянт	Тус бүр 600 үнээтэй	Хувийн хэвшил
31	Холимог тэжээлийн үйлдвэр	Жаргалант сум, Буянт сум	5000тн	Хувийн хэвшил
33	Төмс боловсруулах үйлдвэр	Жаргалант сум	4 тн төмс	Төр, хувийн хэвшил

			боловсруулах хүчин чадалтай	
34	Био бордооны үйлдвэр	Буянт сум	Цагт 500 килограмм бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай	Төр, хувийн хэвшил
35	Зөгийний аж ахуй	Жаргалант сум, Буянт сум	100 бүл зөгийтэй	Хувийн хэвшил
36	Тахианы аж ахуй	Жаргалант сум	5000 өндөглөгч тахиатай	Хувийн хэвшил
37	Чацаргана, жимс, жимсгэний үйлдвэр	Жаргалант сум		Хувийн хэвшил
38	Мал бордох аж ахуй	Буянт сум	1000 үхэр, 1000 хонь бордох аж ахуй	Хувийн хэвшил
39	ХАА-н биотехнологийн төв	Жаргалант сум		Төр хувийн хэвшил
40	Хөх тарианы гурилын үйлдвэр	Булган сум, Жаргалант сум	Хоногт 400 кг гурил үйлдвэрлэх хүчин чадалтай.	Хувийн хэвшил
41	Ургамлын тосны үйлдвэр	Жаргалант сум	Жилдээ 3 тн ургамлын тос үйлдвэрлэх хүчин чадалтай	Хувийн хэвшил
42	Чулууны үйлдвэр	Жаргалант сум	Одоо байгаа нь өдөрт 500м <sup>2</sup> , сард 12500-13500м <sup>2</sup> чулуу үйлдвэрлэх хүчин чадалтай 21500 м <sup>2</sup> хүргэх боломжтой	Хувийн хэвшил
43	Төмөр хийцийн үйлдвэр	Жаргалант сум		Хувийн хэвшил
45	Замаскний үйлдвэр	Жаргалант сум	-Хоногт 500 кг замаска, эмульс үйлдвэрлэх хүчин чадалтай.	Хувийн хэвшил
46	Пивоны үйлдвэр	Жаргалант сум	Хоногт 1.0 тн пиво үйлдвэрлэх хүчин чадалтай	Хувийн
47	Монгол гэрийн үйлдвэр	Жаргалант сум	Дунджаар сард 3-н гэр үйлдвэрлэх	Хувийн
48	Хог хаягдал боловсруулах үйлдвэр	Жаргалант сум	Хоногт 500кг хаягдал цаас боловсруулах хүчин чадалтай.	Хувийн хэвшил
			-Хоногт 50-100м <sup>3</sup> хуванцар боловсруулах хүчин чадалтай.	Хувийн хэвшил
49	Шахмал түлшний үйлдвэр	Жаргалант сум, Дарви сум	-Хоногт 500 ш түлш үйлдвэрлэх. -Ойролцоогоор 50.0-100.0 сая төгрөг	Хувийн
50	Цементийн үйлдвэр	Жаргалант сум,	-Хоногт 10-15 тн	Хувийн

		Буянт сум	цемент үйлдвэрлэх хүчин чадалтай	
<b>Гурав. Нийгмийн салбарын төслүүд</b>				
51.	190 ортой БОЭТ-ийн барилга	Жаргалант сум	190	Улсын төсөв, концесс
52.	Нэгдсэн эмнэлгийн барилга	Булган сум	50	Улсын төсөв, концесс
53.	Аймгийн Халдвартын барилга	Жаргалант сум	30	Улсын төсөв, концесс
54.	Хүүхдийн эмнэлэг	Жаргалант сум	75	Улсын төсөв, концесс
55.	БОЭТ-ийн угаалга, морг, граж барих	Жаргалант сум	х	Улсын төсөв, концесс
56.	Уламжлалт эмчилгээний төв барих	Жаргалант сум	30	Улсын төсөв, концесс
57.	Нялхасын сувилалын төв барих	Жаргалант сум	30	Улсын төсөв, Концесс, Хувийн хэвшил
58.	Эмнэлгийн шингэний үйлдвэр барих	Жаргалант сум	х	Улсын төсөв, Концесс, Хувийн хэвшил
59.	Өрхийн ЭМТ барих	Жаргалант сум	х	Улсын төсөв, Концесс, Хувийн хэвшил
60.	Эмнэлгийн тариур, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр	Жаргалант сум	х	Улсын төсөв, Концесс, Хувийн хэвшил
61.	Соронзон давтамжит компьютерийн томограф (MRI)	Жаргалант сум	х	Улсын төсөв Хандив дэмжлэг
62.	Тархины цахилгаан бичлэгийн аппарат	Жаргалант сум	х	Улсын төсөв Хандив дэмжлэг
63.	Тоноглогдсон машин (БОЭТ/	Жаргалант сум	х	Улсын төсөв Хандив дэмжлэг
64.	Зөөврийн флюор аппарат	Жаргалант сум	х	Хандив
65.	Сургуулийн барилга	Дуут сум	320	Улсын төсөв
66.	Цэцэрлэгийн барилга	Жаргалант сум	200	Улсын төсөв
67.	1-р цэцэрлэгийн барилга	Жаргалант сум	200	Улсын төсөв
68.	Цаст-Алтай сургуулийн барилга	Жаргалант сум	320 суудал	Улсын төсөв
69.	1-р сургуулийн дотуур байрны барилга	Жаргалант сум	150 ор	Улсын төсөв
70.	Ховд их сургуулийн багш, оюутны дотуур байр,	Жаргалант сум		Улсын төсөв
71.	Баруун бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн хотхон	Жаргалант сум		Улсын төсөв



72.	Багшийн хөгжлийн төвийн барилга	Жаргалант сум	8000 багш	Улсын төсөв
73.	Цэцэрлэгийн барилга	Мянгад сум	200 ор	Улсын төсөв
74.	Сургуулийн барилга	Ховд сум	320	Улсын төсөв
75.	Сургуулийн барилга	Цэцэг сум	320	Улсын төсөв
76.	Цэцэрлэгийн барилга	Чандмань сум	150	Улсын төсөв
77.	Цэцэрлэгийн барилга	Эрдэнэбүрэн сум	150	Улсын төсөв
78.	Цэцэрлэгийн барилга	Жаргалант сум	200	Улсын төсөв концесс
79.	Цэцэрлэгийн барилга	Жаргалант сум	100	Улсын төсөв концесс
80.	Турк коллеж сургууль	Жаргалант сум	300	Улсын төсөв концесс
81.	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Дарви сум	150	Улсын төсөв ОНХС
82.	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Дөргөн сум	100	Улсын төсөв ОНХС
83.	8-р цэцэрлэгийн барилга	Жаргалант сум	120	Улсын төсөв
84.	2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Жаргалант сум	150	Улсын төсөв
85.	10-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Жаргалант сум	95	Улсын төсөв
86.	9-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Жаргалант сум	95	Улсын төсөв
87.	Ховд политехникийн коллежийн өргөтгөл	Жаргалант сум		Улсын төсөв ОНХС
88.	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Манхан сум	150	Улсын төсөв ОНХС
89.	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Мөнххайрхан сум	150	Улсын төсөв ОНХС
90.	Сургуулийн барилгын өргөтгөл	Мөнххайрхан сум	320	Улсын төсөв
91.	6-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Жаргалант сум	95	Улсын төсөв
92.	Хөгжимт драмын театрын барилга	Жаргалант сум	800	Улсын төсөв ОНХС
93.	Музейн барилга	Жаргалант сум		Улсын төсөв ОНХС
94.	Номын санг өргөтгөж цахим болох	Жаргалант сум		Улсын төсөв
95.	Буянт голын хөвөөнд аялал жуулчлалын ногоон парк байгуулах	Буянт сум	200	Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт

96.	Байгалийн болон угсаатны аялал жуулчлалын цогцолбор	Жаргалант, Булган сум	200-300	Улсын төсөв
97.	Аялал жуулчлалын бааз байгуулах	Ховд, Дуут, Мөнххайрхан, Мөст, Цэцэг, Алтай, Үенч, Эрдэнэбүрэн сум	200	Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
98.	3-5 одтой Зочид буудал байгуулах	Жаргалант сум		Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт
99.	Хүүхдийн хөдөлмөр амралтын зуслан	Булган сум	100 хүүхдийн зуслан	Улсын төсөв